



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

2023

ЗАМ ТЭЭВЭР



СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ

СУДАЛГАА, СТАНДАРТ,
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2024 ОН

АГУУЛГА

ДҮГНЭЛТ.....	5
БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ.....	8
Ачаа тээвэр.....	8
Зорчигч тээвэр.....	14
Тээврийн орлого.....	17
Салбарын ажиллагсад.....	18
БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР.....	21
БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....	24
Зорчигч тээвэр.....	24
Ачаа тээвэр.....	25
Мэргэшсэн жолооч.....	28
Тээврийн хэрэгслийн бүртгэл.....	29
БҮЛЭГ 4. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР.....	33
Зорчигч тээвэр.....	33
Ачаа тээвэр.....	34
Галт тэрэг солилцоо.....	38
Хөдлөх бүрэлдэхүүн.....	38
Суурь бүтэц.....	40
БҮЛЭГ 5. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР.....	42
Зорчигч тээвэр.....	42
Ачаа тээвэр.....	45
Нислэгийн үзүүлэлт.....	46
БҮЛЭГ 6. ДАЛАЙН ТЭЭВЭР УСАН ЗАМЫН САЛБАР.....	46
Зорчигч тээвэр.....	47
Тээврийн хэрэгслийн бүртгэл.....	47
МУ-ын далбаатай хөлөг онгоцны бүртгэл.....	48
ХАВСРАЛТ.....	49

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Нийт тээсэн ачаа	8
Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт	9
Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин	9
Зураг 4 Ачаа эргэлт, сая.тонн/км.....	9
Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар.....	10
Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт	10
Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр	10
Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	11
Зураг 9 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин	12
Зураг 10 Тээвэрлэлийн төрөл, салбараар	12
Зураг 11 Улс хоорондын ачаа тээвэр.....	12
Зураг 12 Ачаа гаргалт (экспорт).....	13
Зураг 13 Ачаа оруулалт (импорт)	13
Зураг 14 Зорчигч тээвэр.....	14
Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт	15
Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь	15
Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр	15
Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр	16
Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км	16
Зураг 20 Тээврийн орлого, тэрбум төгрөг.....	17
Зураг 21 Орлогын эзлэх хувь.....	18
Зураг 22 Зам, тээврийн салбарт ажиллагсад	19
Зураг 23 Салбарын ажиллагсдын эзлэх хувь.....	19
Зураг 24 Салбарын дундаж цалин	19
Зураг 25 Улсын чанартай авто зам	21
Зураг 26 Орон нутгийн чанартай авто зам.....	21
Зураг 27 Тусгай зориулалтын авто зам	21
Зураг 28 Улсын чанартай авто замын гүүр	21
Зураг 29 Улсын чанартай авто замын сүлжээ	21
Зураг 30 Улсын чанартай авто замын сүлжээний урт км, аймгаар.....	23
Зураг 31 Улсын чанартай авто замд хатуу хучилттай авто замын эзлэх хувь, урт км.....	23
Зураг 32 Автотээврийн зорчигч, сая хүн	24
Зураг 33 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр	24
Зураг 34 Автотээврийн зорчигч эргэлт	24
Зураг 35 Автотээврийн экспортын ачаа	25
Зураг 36 Экспортын ачаа, эзлэх хувь.....	26
Зураг 37 Автотээврийн импортын ачаа	26
Зураг 38 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь.....	27
Зураг 39 Мэргэшсэн жолоочийн ангилал.....	28
Зураг 40 Тээврийн хэрэгслийн ангилал.....	29
Зураг 41 Жолооны хүрдний байрлал	29
Зураг 42 Хөдөлгүүрийн багтаамж.....	29
Зураг 43 Тээврийн хэрэгслийн импорт – улсаар, тээврийн хэрэгслийн төрлөөр	30
Зураг 44 Автомашины насжилт.....	30
Зураг 45 Орон нутаг дахь тээврийн хэрэгслийн төрөл.....	32
Зураг 46 Төмөр замын зорчигч эргэлт.....	33
Зураг 47 Төмөр замын ачаа эргэлт	34
Зураг 48 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь.....	35
Зураг 49 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин	35

Зураг 50 Төмөр замын улс хоорондын ачаа тээвэр, эзлэх хувь	35
Зураг 51 Төмөр замын экспортын тээврийн хэмжээ, эзлэх хувь	36
Зураг 52 Төмөр замын импортын тээврийн хэмжээ, эзлэх хувь	36
Зураг 53 Төмөр замаар дамжин өнгөрсөн ачаа тээврийн хэмжээ, эзлэх хувь	36
Зураг 54 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх хувь	36
Зураг 55 Төмөр замаар тээсэн ачааны төрөл	36
Зураг 56 Төмөр замаар тээсэн ачааны өөрчлөлт	37
Зураг 57 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл	37
Зураг 58 Хүлээн авсан вагон	38
Зураг 59 Хүлээлгэн өгсөн вагон	38
Зураг 60 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл	39
Зураг 61 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч	39
Зураг 62 Төмөр замын сүлжээний урт	40
Зураг 63 Суурь бүтэц эзэмшигч	40
Зураг 64 Монгол Улсын үндэсний төмөр замын сүлжээ	41
Зураг 65 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь	42
Зураг 66 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд	42
Зураг 67 Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр	43
Зураг 68 Олон улсын зорчигч, чиглэлээр	43
Зураг 69 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр	43
Зураг 70 Орон нутгийн зорчигч, чиглэлээр	44
Зураг 71 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр	44
Зураг 72 Ачаа, шуудангийн эзлэх хувь	45
Зураг 73 Ачаа тээврийн үзүүлэлт	45
Зураг 74 Нислэгийн үзүүлэлт	46
Зураг 75 Салбарын орлогын үзүүлэлт	46
Зураг 76 Усан замын зорчигч тээвэр	47
Зураг 77 Бүртгэлтэй тээврийн хэрэгсэл	47
Зураг 78 Усан замын тээврийн хэрэгсэл, аймгаар	47
Зураг 79 Техник хяналтын үзлэгийн дүн	48
Зураг 80 Бүртгэлтэй хөлөг онгоцны тоо	48

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт	Тодорхойлолт*
Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Нэмэхжаргал

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Энхзаяа

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

ДҮГНЭЛТ

Ачаа тээвэр

Зам, тээврийн хөгжлийн яамнаас тээвэр зохион байгуулалтын шуурхай, найдвартай байдлыг хангах, бүх төрлийн тээврийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого зорилт дэвшүүлж ажилласны үр дүнд ачаа болон зорчигч тээврийн хэмжээ нэмэгдсэн.

Зам, тээврийн салбар 2023 онд бүх төрлийн тээврээр нийт 107.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 76.6%-аар өслөө. Мөн ачаа эргэлт 2022 онд 17.5 сая.тн/км байсан бол 2023 онд 29.5 сая.тн/км болж 68.3%-аар өссөн байна.

Автотээврийн ачаа 71.3 сая тонн болж өмнөх оноос 2.1 дахин, төмөр замын тээврийн ачаа 36.1 сая тонн болж өмнөх оноос 30.3%-аар тус тус өссөн бол агаарын тээврийн ачаа 8.57 мянган тонн болж өмнөх оноос 33.5%-аар буурсан байна.

Нийт ачаа тээврийн 66.36%-ийг автотээвэр, 33.63%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Ачаа тээврийн хэмжээ өсөхөд уул уурхайн олборлолт 50%-аар, нийт экспорт 21%-аар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. 2023 онд тээвэрлэсэн нийт ачааны 87.6%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 4.1%-ийг барилгын салбарын бүтээгдэхүүн, 1.3%-ийг хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 6.9%-ийг бусад салбарын ачаа эзэлж байна.

Үүнээс автотээврээр тээвэрлэсэн ачааны 94.9%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 67.2% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

Бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн экспортын ачаа нийт ачаа тээврийн 73.9%-ийг эзэлж байгаа бөгөөд 2023 онд 79.4 сая тонн болж өмнөх оноос 95.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс 78.4 сая тонн буюу 98.7%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 86.2%-ийг автотээврээр, 13.8%-ийг төмөр замаар тээвэрлэжээ.

2023 онд бүх төрлийн тээврийн хэрэгслээр тээсэн дотоодын ачаа 16.3 сая тонн болж өмнөх оноос 35.4%, импортын ачаа 6.6 сая тонн болж өмнөх оноос 33.4%, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.1 сая тонн болж өмнөх оноос 60.5%-аар тус тус өсчээ.

2022 онд улс хоорондын ачаа тээвэр 45.6 сая тонн болж нийт ачаа тээврийн 75.0%-ийг эзэлж байсан бол 2023 онд 86.0 сая тонн болж нийт ачаа тээврийн 80.1% болж өссөн байна.

2023 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.3% нь БНХАУ-тай, 3.7% нь ОХУ-тай хиллэж буй боомтоор орж, гарсан байна. БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 95.4% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 88.9% нь импортын ачаа байна.

Зорчигч тээвэр

2023 онд бүх төрлийн тээврээр нийт 146.5 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 0.1%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр зорчигчдын тоо 2023 онд 140.3 сая байна.

Бүх төрлийн тээврээр олон улс болон орон нутагт зорчигчдын тоо 2023 онд 6.2 сая болж өмнөх оноос 31.2%-аар өслөө. Үүнээс агаарын тээврээр 1.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 81.7%, усан замаар 64.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оноос 71%, автотээврээр 2.3 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 67.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 2.1 сая зорчигч зорчсон нь өмнөх оноос 10%-аар буурчээ.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 онд агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэх, олон улсын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээх бодлого баримталж ажилласны үр дүнд олон улсын зорчигч тээвэрлэлт бүх салбарт өссөн үзүүлэлттэй гарсан

бөгөөд нийт 2.2 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 3.2 дахин өслөө.

Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 1.3 сая болж өмнөх оноос 2.1 дахин өссөн нь нийт олон улсад зорчигчдын 60.0%-ийг эзэлж байна.

Автотээвэр болон төмөр замаар олон улсад зорчсон зорчигчдын 83.8% нь Замын-Үүдийн боомтоор нэвтэрсэн бол 5.1% нь Алтанбулагийн боомтоор, 11.1% нь бусад боомтуудаар нэвтэрсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 онд орон нутгийн нислэгийг сэргээх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг баримтлан ажилласан бөгөөд орон нутгийн 3 чиглэлд нислэг үйлддэг байсныг 8 болгон нэмэгдүүлж, нислэгийн тийзийн үнийг 2-2.5 дахин хямдруулсан.

Энэхүү бодлогын арга хэмжээний үр дүнд агаарын тээврээр орон нутагт зорчигчдын тоон өсөлт хамгийн өндөр хувиар буюу 25.6%-аар өсч 419.1 мянга болсон байна.

Тээврийн орлого

2023 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарим салбарт ачаа болон зорчигч тээврийн үнэ тарифыг тодорхой түвшинд бууруулах бодлого баримтлан ажилласан нь үр дүнгээ өгч, автотээврийн зардлыг цар тахлын үетэй харьцуулахад 7-8 дахин, агаарын тээврийн тийзийн үнийг 2-2.5 дахин бууруулсан.

Гэсэн хэдий ч, 2023 онд тээврийн нийт орлого 7.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 70.1%-аар өсчээ. Үүнээс автотээврийн орлого 5.5 их наяд төгрөг болж өмнөх оноос 72.5%-аар, төмөр замын тээврийн орлого 1.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 50.4%-аар, агаарын тээврийн орлого 941.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 83.6%-аар, усан замын тээврийн орлого 1.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.5 дахин өссөн түүхэн өсөлттэй жил байлаа.

Үүнд, ачаа болон зорчигч тээврийн хэмжээ нэмэгдсэн нь бүх төрлийн тээврийн орлого нэмэгдэж түүхэн дээд хэмжээнд хүрэхэд нөлөөлсөн бөгөөд, цар тахлын өмнөх үеэс буюу 2019 оны түвшингээс өссөн үзүүлэлттэй байна.

Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн аялал

жуулчлалыг дэмжих бодлого болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болгон тодорхойлсон агаарын тээврийн либералчлалын бодлого үр дүнгээ өгч, сүүлийн жилүүдэд цар тахал, валютын ханш, инфляц, үнийн өсөлт зэргээс шалтгаалан зогсонги байдалд ороод байсан агаар, усан замын тээврийн салбаруудын орлогын өсөлт хамгийн өндөр хувиар өсөхөд нөлөөллөө.

Орлогын өсөлтийг мөнгөн дүнгээр авч үзвэл, автотээврийн орлого 2.3 их наяд төгрөгөөр өссөн нь хамгийн өндөр дүнгээр өссөн үзүүлэлт бол агаарын тээврийн орлого өмнөх оноос 428.9 тэрбум төгрөгөөр, төмөр замын тээврийн орлого 376.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь удаалж байна.

Салбарын ажиллагсад

Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 83.7 мянган албан хаагч ажиллаж байгаа нь өмнөх оноос 15.5 мянгаар буюу 22.7%-аар өсчээ.

Үүнээс автотээврийн салбарт нийт ажиллагсдын 56.4% буюу нийт 47.1 мянган ажилтан, албан хаагч ажиллаж байна.

Салбарын нийт ажиллагсдын 21.0% буюу 17.6 мянган албан хаагч төмөр замын салбарт, 18.3% буюу 15.3 мянга албан хаагч авто замын салбарт, 4.2% буюу 3.5 мянган албан хаагч иргэний нисэхийн салбарт тус тус ажиллаж байна.

Зам тээврийн салбарт 14.4 мянга нь эмэгтэй ажилчид байгаа нь салбарын нийт ажиллагсдын 17.3% эзэлж байна

Тээврийн дэд бүтэц*Авто зам*

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,921.3 км авто зам, орон нутгийн чанартай 96,040 км авто зам, тусгай зориулалтын 955.8 км авто зам байна.

2023 оны байдлаар 21 аймаг, 104 сум хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдсон. ОХУ, БНХАУ-тай хиллэдэг 7 боомт хатуу хучилттай авто замаар холбогдлоо.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 чиглэл дайран өнгөрдөг бөгөөд 2022 онд АН-4 баруун босоо тэнхлэгийн олон улсын чанартай авто замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгаж, 2023 онд улс хоорондын тээврийг эхлүүлээ.

2023 онд нийт 381.4 км хатуу хучилттай авто зам, 841.9 урт метр гүүр шинээр ашиглалтад орууллаа. Ингэснээр олон улс, улсын чанартай 7,535.6 км, орон нутгийн чанартай 1,815.6 км, тусгай зориулалтын 955.8 км, нийт 10,307 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

Төмөр зам

Сүүлийн 3 жилийн хугацаанд төмөр замын сүлжээний гол замын уртыг 928 км-ээр, салбар замын уртыг 192.1 км-ээр, нийт уртыг 1,120.1 км-ээр нэмэгдүүлжээ.

2023 онд Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км замын туршилтын тээврийг эхлүүлснээр Монгол Улсын төмөр замын сүлжээний суурь бүтцийн техникийн хүчин чадал буюу дэлгэмэл урт 286.9 км-ээр нэмэгдэж нийт урт 3,349.6 км боллоо.

Үүнээс гол төмөр замын урт 2,413.0 км, салбар төмөр замын урт 936.6 км байна.

Монгол Улс төмөр замын суурь бүтэц эзэмшигч төр, хувийн хэвшлийн нийт 6 байгууллагатай болсноор үндэсний төмөр замын сүлжээтэй болоод байна.

Тээврийн хэрэгсэл*Автомтээвэр*

2023 оны жилийн эцсийн байдлаар 1,192,520 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа

нь өмнөх оноос 111,308 тээврийн хэрэгслээр нэмэгдсэн буюу 10.3%-аар өссөн байна.

Улаанбаатар хотод 697,870 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 58.6%-ийг, орон нутагт 494,650 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 41.4%-ийг эзэлж байна.

Хамгийн өндөр өссөн үзүүлэлт нь цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл нийт 1,072 болж өмнөх оноос 413 буюу 62.7%-аар өссөн.

Хөдлөх бүрэлдэхүүн

Төмөр замын салбарт 2023 оны 12 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар хөдлөх бүрэлдэхүүний нийт тоо 12,235 байгаагаас хагас вагон 6,874, тавцант вагон 2,439, зорчигчийн вагон 321, зүтгүүр 190, машин механизм 83, бусад 2,328 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна.

Хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмшдэг байгууллагаар нь авч үзвэл, хувийн хэвшил 8,011 хөдлөх бүрэлдэхүүн буюу нийт хөдлөх бүрэлдэхүүний 66%, “УБТЗ” ХНН 3,406 хөдлөх бүрэлдэхүүн буюу 30%, төрийн өмчит компаниуд 498 хөдлөх бүрэлдэхүүн буюу 4%-ийг тус тус эзэмшиж байна.

Агаарын хөлөг

2023 оны байдлаар Монгол улсад 60 агаарын хөлөг бүртгэлтэй байгаагаас 18 нь иргэний агаарын тээврийн хөлөг байна.

Усан замын тээврийн хэрэгсэл

Монгол Улсад дотоодын усан замын 206 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. 2023 онд 146 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нь өмнөх оноос 42 тээврийн хэрэгслээр буюу 40.4%-аар нэмэгджээ.


БҮЛЭГ 1. САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2023 ОНД АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ 107.4 САЯ ТОНН БОЛЖ ТҮҮХЭН АМЖИЛТ ТОГТООЛОО.

Ачаа тээвэр


Бүх төрлийн тээврээр 2023 онд нийт 107.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 76.6%-аар өслөө. Үүнээс автотээврийн ачаа 71.3 сая тонн болж өмнөх оноос 2.1 дахин, төмөр замын тээврийн ачаа 36.1 сая тонн болж өмнөх оноос 30.3%-аар тус тус өссөн бол агаарын тээврийн ачаа 8.57 мянган тонн болж өмнөх оноос 33.5%-аар буурсан байна.

Нийт ачаа эргэлт 2022 онд 17.5 сая.тн/км байсан бол 2023 онд 29.5 сая.тн/км болж 68.3%-аар өслөө.




Тээврийн төрөл	2019	2020	2021	2022	2023
Нийт тээсэн ачаа, мянган тонн	68,997.5	60,297.8	49,238.1	60,813.4	107,377.6
Төмөр зам	28,143.0	29,840.1	31,261.4	27,724.9	36,114.1
Автотээвэр	40,848.8	30,455.0	17,970.3	33,075.6	71,254.9
Агаарын тээвэр	5.8	2.7	6.4	12.9	8.6
Нийт ачаа эргэлт, сая.тн/км	23,601.8	23,861.0	20,674.6	17,534.1	29,512.7
Төмөр зам	17,384.1	19,167.6	18,345.1	14,910.2	18,869.3
Автотээвэр	6,203.8	4,685.3	2,313.9	2,591.9	10,619.1
Агаарын тээвэр	13.9	8.1	15.6	32.0	24.3

Зураг 1 Нийт тээсэн ачаа




2023 онд бүх төрлийн тээврээр тээсэн нийт ачаа болон авто тээвэр, төмөр замаар тээсэн ачааны хэмжээ тус тус түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн бөгөөд 2019-2022 оны жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулвал, нийт тээсэн ачаа 79.4%, автотээврийн ачаа 2.3 дахин, төмөр замын тээврийн ачаа 32.9%-аар тус тус илүү байна.

Зураг 2 Ачаа тээврийн өөрчлөлт




2022 онд нийт ачаа тээврийн дүнд автотээвэр 54.4%, төмөр замын тээвэр 45.6%, агаарын тээвэр 0.02%-ийг тус тус эзэлж байсан бол 2023 онд 66.36%-ийг автотээвэр, 33.63%-ийг төмөр замын тээвэр, 0.01%-ийг агаарын тээврийн ачаа эзэлж байна. Үүнд автотээврийн өсөлт төмөр замын тээврийн өсөлтөөс 4.5 дахин өндөр байсан нь нөлөөлжээ.

Зураг 3 Тээврийн салбарын эзлэх жин



Зураг 4 Ачаа эргэлт, сая.тонн/км



2023 онд ачаа эргэлт өндөр өсөлттэй байсан цар тахлын өмнөх түвшингээс давлаа. Нийт ачаа эргэлт 29,512.7 сая.тн/км болж 2019 оны түвшингээс 25%-аар өссөн бол өмнөх оноос 68.3%-аар өсчээ.

Автотээврийн ачаа эргэлт хамгийн өндөр хувиар өслөө. 2023 онд 10,619.1 сая.тн/км болж өмнөх оноос 4.1 дахин, 2019 онтой харьцуулахад 71.2%-аар өссөн байна.

Нийт ачаа эргэлтэд төмөр замын ачаа эргэлт хамгийн өндөр үзүүлэлттэй хэвээр байна. 2023 онд 18,869.3 сая.тн/км болж өмнөх оноос 26.6%, 2019 оны түвшингээс 8.5%-аар өсчээ.

Агаарын тээврийн ачаа эргэлт 24.3 сая.тн/км болж 2019 онтой харьцуулахад 74.8%-аар өссөн хэдий ч өмнөх оноос 24.0%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Шилжүүлсэн сая.тн/км	2022 он	2023 он	Өсөлт
Төмөр зам	15,611.7	19,667.0	26.0%
Автотээвэр	5,997.4	7,813.4	30.3%
Агаарын тээвэр	198.5	377.6	90.2%

Шилжүүлсэн тн.км-ээр тооцсон тээврийн үзүүлэлт мөн бүх салбарт өсөлттэй байлаа. Өмнөх онтой харьцуулахад хамгийн өндөр дүнгээр буюу 4,055.3 сая.тн/км-ээр өссөн нь төмөр замын тээвэр байсан бол өсөлтийн хамгийн өндөр хувийг агаарын тээврийн салбар үзүүлжээ.

Ачаа тээврийн хэмжээ өсөхөд уул уурхайн олборлолт 50%-аар, нийт экспорт 21%-аар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

2023 онд нийт 107.4 сая тонн ачаа тээвэрлэснээс 94.1 сая тонн буюу 87.6%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн, 4.4 сая тонн буюу 4.1%-ийг барилгын салбарын бүтээгдэхүүн, 1.4 сая тонн буюу 1.3%-ийг хүнс хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, 7.5 сая тонн буюу 6.9%-ийг бусад салбарын ачаа эзэлж байна.

Зураг 5 Ачаа тээвэр, эдийн засгийн салбараар



Эдийн засгийн салбарын ачаа тээврийн өөрчлөлт нь тухайн салбарын өсөлт, бууралттай шууд хамааралтай байна.

2023 онд автотээврээр тээвэрлэсэн ачааны 94.9%, төмөр замаар тээвэрлэсэн ачааны 67.2% нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

Уул уурхайн олборлолт болон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ өссөн нь 2022 онд 37.4%-ийн өсөлттэй байсан уг салбарын тээвэрлэлтийн хэмжээг 2023 онд 85.9%-аар өсөхөд нөлөөлжээ.

Зураг 7 Ачаа тээврийн хэмжээ, тээвэрлэлтийн төрлөөр

Барилгын салбарын түүхий эд, бүтээгдэхүүний тээврийн хэмжээ 2022 онд өмнөх оноос 19.3%-аар буурсан байсан бол 2023 онд 4.4 сая тонн болж, 9.3%-аар өссөн үзүүлэлттэй байна.


2023 онд хөдөө, аж ахуйн салбарын өсөлт саарсан нь уг салбарын бүтээгдэхүүний тээврийн хэмжээнд нөлөөлж, 44.4%-аар буурахад хүргэжээ. 2022 онд 2.6 сая тонн бүтээгдэхүүн тээвэрлэж байсан бол 2023 онд 1.4 сая тонн болсон байна.


Харин худалдаа, үйлчилгээ, үйлдвэрийн салбарт өсөлт гарсан нь эдгээр салбаруудыг оролцуулаад бусад салбарын бүтээгдэхүүний ачаа тээврийн хэмжээг 7.5 сая тоннд хүргэж, 106.8%-аар өсөхөд нөлөөлжээ.

78.4 сая тонн буюу экспортын тээврийн 98.7%-ийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийн 86.2% буюу 67.5 сая тонн ачааг автотээврээр, 13.8% буюу 10.8 сая тонн ачааг төмөр замаар тээвэрлэсэн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээврийг бүтээгдэхүүнээр авч үзвэл, 69.7 сая тонн буюу 88.9%-ийг нүүрс, 5.6 сая тонн буюу 7.2%-ийг төмрийн хүдэр, 1.3 сая тонн буюу 1.7%-ийг зэсийн баяжмал, 524.6 мянган тонн буюу 0.7%-ийг газрын тос, 144.8 мянган тонн буюу 0.2%-ийг цайрын баяжмал тус тус эзэлж байна.

Зураг 6 Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт





2023 онд ачаа тээврийн хэмжээ тээвэрлэлтийн бүх төрлөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2022 он	2023 он
Нийт тээсэн ачаа, сая тонн		60,813.4	107,377.6
Транзит	Төмөр зам	3,174.5	5,094.4
	Нийт		
Экспорт	Төмөр зам	8,642.5	11,128.9
	Автотээвэр	32,004.9	68,245.0
	Нийт	40,647.4	79,373.8
Импорт	Төмөр зам	3,905.9	3,629.5
	Автотээвэр	1,070.7	3,010.0
	Нийт	4,976.6	6,639.5
Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	12,002.0	16,261.3
	Агаар	12.89	8.57
	Нийт	12,014.9	16,269.9

дотоодын ачаа 16.3 сая тонн болж өмнөх оноос 35.4%, импортын ачаа 6.6 сая тонн болж өмнөх оноос 33.4%-аар, төмөр замаар дамжин өнгөрөх транзит тээврийн хэмжээ 5.1 сая тонн болж өмнөх оноос 60.5%-аар тус тус өсчээ.

2022 онд буурсан үзүүлэлттэй байсан дотоодын (-5.2%) болон төмөр замаар дамжин өнгөрөх транзит (-25.1%) тээврийн хэмжээ өсөхөд гадаад худалдааны эргэлт 15%-аар, худалдааны салбарын нийт борлуулалт (оны эхний 11 сарын байдлаар) 18.4%-аар өссөн зэрэг эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сайжирсан болон Орос, Хятадын хоорондын худалдаа эрчимжсэн нь нөлөөлсөн байна.

Экспортын хэмжээ 95.3%-аар, автотээвэр 2.1 дахин өссөнтэй холбоотойгоор тээвэрлэлтийн бусад төрлийн нийт тээврийн хэмжээнд эзлэх хувьд томоохон өөрчлөлт оржээ.

Зураг 8 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин

Бүх төрлийн тээврээр тээсэн экспортын ачаа 79.4 сая тонн болж өмнөх оноос 95.3%-аар,




2022 онд 66.8%-ийг эзэлж байсан экспортын тээвэр 73.9% болж өссөн бол импортын ачаа өмнөх оноос 33.4%-аар өссөн хэдий ч нийт тээврийн хэмжээнд эзлэх хувь 8.2%-аас 6.2% болж өөрчлөгджээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын транзит тээврийн эзлэх хувь 4.7% байна.

Дотоодын ачаа тээвэр 2022 онд 12.0 сая тонн буюу нийт ачаа тээврийн 19.6%-ийг эзэлж байсан бол 2023 онд 16.3 сая тонн болж өссөн нь 15.1%-ийг эзэлжээ.

Зураг 9 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх жин




Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэсэн нь дотоодын ачааны өсөлтөд нөлөөлжээ.

2023 онд "Монголын төмөр зам" ТӨХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-иуд дотоодын ачааны 23%-ийг тээвэрлэсэн бол "Улаанбаатар

төмөр зам" ХХН 12.5 сая тонн буюу 77%-ийг тээвэрлэжээ.

2023 онд автотээвэрээр тээсэн экспортын тээвэр өмнөх оноос 2.1 дахин, импортын тээвэр 2.8 дахин өссөн нь хамгийн өндөр өсөлт байв.

Зураг 10 Тээвэрлэлийн төрөл, салбараар




Улс хоорондын ачаа тээвэр буюу экспорт, импортын ачаа тээврийг төмөр зам, автотээвэрээр гүйцэтгэж байгаа бол транзит тээвэр болон дотоодын тээвэрт төмөр зам голлох үүрэг гүйцэтгэж байна.

2023 онд автотээвэрээр экспортын ачааны 86%, импортын ачааны 45.3%-ийг тээсэн бол төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 54.7%, экспортын ачааны 14%-ийг тээвэрлэжээ.

2023 онд анх удаа Замын-Үүд-Эрээний галт тэрэг солилцоо хоногт өргөн царигаар 16, нарийн царигаар 8 галт тэрэг болж нэмэгдсэн нь төмөр замаар тээх экспортын ачаа нэмэгдэхэд нөлөөлжээ.

Монгол Улс өнөөдөр хоёр хөрштэйгөө төмөр замын 3 боомт, авто замын 13 боомтоор экспорт, импортын тээвэр хийж байна.

Зураг 11 Улс хоорондын ачаа тээвэр



2022 онд улс хоорондын ачаа тээвэр 45.6 сая тонн болж нийт ачаа тээврийн 75.0%-ийг эзэлж байсан бол 2023 онд 86.0 сая тонн болж нийт ачаа тээврийн 80.1% болж өссөн байна.

2023 онд тээсэн улс хоорондын ачаа тээврийн 96.3% нь БНХАУ-тай хиллэж буй 10 боомтоор, 3.7% нь ОХУ-тай хиллэж буй 3 боомтоор орж, гарсан байна.


Үүнээс хамгийн их буюу 43.7% Гашуунсухайт, 22.2% нь Шивээхүрэн, 16.8% нь Замын-Үүд, 5.8% нь Ханги боомтоор орж, гарсан бол Алтанбулаг боомтоор 2.9 сая тонн ачаа буюу 3.4% нь орж, гарчээ.

БНХАУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 95.4% экспортын ачаа байгаа бол ОХУ-тай харилцан тээвэрлэсэн ачааны 88.9% нь импортын ачаа байна.

Монгол Улсын экспортын ачааны 99.5% БНХАУ руу гарсан бол импортын ачааны 57.1% нь БНХАУ-аас, 42.9% ОХУ-аас орж иржээ.


2023 онд Гашуунсухайт боомтоор хамгийн их буюу 36.7 сая тонн ачаа гарсан нь нийт ачаа гаргалтын 46%-ийг эзэлж байгаа бол Шивээхүрэн боомтоор 24%, Замын-Үүд боомтоор 15% нь гарчээ.

Зураг 12 Ачаа гаргалт (экспорт)



2023 онд нийт импортын ачааны 42.7% нь Замын-Үүд, 40.4% нь Алтанбулаг боомтоор орж ирсэн бол Гашуунсухайт боомтоор 12.8% нь орж ирсэн нь боомтуудын ачаа оруулалтын эзлэх хувьд томоохон өөрчлөлт орууллаа.


Зураг 13 Ачаа оруулалт (импорт)



Замын-Үүд боомтоор БНХАУ-аас орж ирж буй импортын ачааны 74.8% буюу 3.8 сая тонн ачаа, Гашуунсухайтын боомтоор 22.5% буюу 851.9 мянган тонн ачаа орж ирсэн бол Булган боомтоор 73.5 мянган тонн ачаа буюу 1.9% нь орж иржээ.

ОХУ-аас орж ирж буй импортын ачааны хувьд 94.1% буюу 2.7 сая тонн ачаа Алтанбулаг боомтоор орж ирсэн бол Цагааннуур боомтоор 4.7%, Боршоо боомтоор 1.2% нь орж ирсэн байна.

2023 ОНД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРЭЭР 146.5 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.




Зорчигч тээвэр

Бүх төрлийн тээвэрээр 2023 онд нийт 146.5 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 0.1%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчдын тоо 140.3 сая байна.

Үүнээс агаарын тээвэрээр 1.7 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 81.7%, усан замаар 64.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 71%-аар тус тус өссөн бол автотээвэрээр 142.5 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 0.3%, төмөр замаар 2.1 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 10%-аар тус тус буурсан байна.

Тээврийн төрөл	2019	2020	2021	2022	2023
Нийт зорчигчдын тоо, сая хүн	173.0	126.5	107.1	146.3	146.5
Автотээвэр	168.4	124.1	106.5	143.0	142.6
Төмөр замын тээвэр	3.0	2.0	0.4	2.4	2.1
Агаарын тээвэр	1.6	0.4	0.2	0.9	1.7
Усан замын тээвэр	0.01	0.00	0.02	0.04	0.06
Зорчигч эргэлт, сая хүн/км	7,146.18	3,416.87	1,563.44	4,444.8	6,492.7
Автотээвэр	2,925.09	2,178	1,023.01	1,914.9	1,813.2
Төмөр замын тээвэр	1,111.5	579.3	90.66	701.5	797.5
Агаарын тээвэр	3,109.4	659.57	449.37	1,828.4	3,880.8
Усан замын тээвэр	0.19	0	0.4	0.9	1.2

Зураг 14 Зорчигч тээвэр



2022 онд автотээврийн зорчигчийн 99.1%-ийг нийслэлийн тээврийн зорчигч эзэлж

байсан бол 2023 онд 98.4% болж эзлэх хувь буурсан нь автотээвэрээр орон нутаг болон олон


улсад зорчсон зорчигчийн тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Үзүүлэлт	Тээврийн төрөл	2022 он	2023 он
Нийт зорчигч			
		146,373.5	146,490.8
Олон улсад зорчигч	Автотээвэр	34.7	850.2
	Төмөр зам	19.1	23.7
	Агаарын тээвэр	619.0	1,312.2
	Нийт	672.8	2,186.0
Орон нутагт зорчигч	Автотээвэр	1,321.6	1,417.1
	Төмөр зам	2,363.7	2,118.1
	Агаарын тээвэр	333.8	419.1
	Усан зам	37.9	64.7
Нийт	4,057.0	4,019.0	
Нийслэлд зорчигч	Автотээвэр	141,643.7	140,285.7

Цар тахлаас үүдэлтэй огцом буурсан зорчигч тээврийн хэмжээ сүүлийн жилүүдэд өссөөр байна.

2023 онд бүх төрлийн тээврээр улс хооронд болон хот хооронд зорчсон зорчигчдын тоо 6.2 сая болж өмнөх оноос 31.2%-аар өслөө.


Зураг 15 Зорчигч тээврийн өөрчлөлт



Үүнээс агаарын тээврээр 1.7 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 81.7%, усан замаар 64.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 70.6%, автотээврээр 2.3 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 67.2%-аар тус тус өссөн бол төмөр замаар 2.1 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.1%-аар буурсан байна.


Тээврийн төрлөөр авч үзвэл, автотээврээр 36.5%, төмөр замаар 34.5%, агаарын тээврээр 27.9%, усан замаар 1% нь зорчсон байна.

Зураг 16 Зорчигч тээврийн эзлэх хувь



Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 онд агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэх, олон улсын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээх бодлого баримталж ажилласны үр дүнд олон улсын зорчигч тээвэрлэлт бүх салбарт өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр нийт 2.2 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 3.2 дахин өслөө.

Зураг 17 Олон улсын зорчигч тээвэр



Үүнээс агаарын тээврээр олон улсад зорчигчдын тоо 1.3 сая болж өмнөх оноос 2.1 дахин өссөн нь нийт олон улсад зорчигчдын 60.0%-ийг эзэлж байна.

2023 онд цар тахлаас үүдэлтэй зогсоод байсан Монгол улс, БНХАУ хоорондын автотээврийн болон төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээлээ.

Бодлогын хэрэгжилтийн үр дүнд автотээврээр олон улсад зорчигчдын тоо 2022 онд 34.7 мянга байсан бол 850.2 мянга болж өмнөх оноос 24.5 дахин өссөн.


2023 оны 8 дугаар сараас төмөр замын олон улсын зорчигч тээврийг эхлүүлсэн бөгөөд

23.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх жилээс 24.1%-аар өсчээ.

Автотээвэр болон төмөр замаар олон улсад зорчсон зорчигчдын 83.8% нь Замын-Үүдийн боомтоор нэвтэрсэн бол 5.1% нь Алтанбулагийн боомтоор, 11.1% нь бусад боомтуудаар нэвтэрсэн байна.

Бүх төрлийн тээврээр орон нутагт зорчигчдын тоо 2023 онд 4.0 сая болж өмнөх оноос 0.9%-аар буурсан байна.

Зураг 18 Орон нутгийн зорчигч тээвэр



Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 онд орон нутгийн зорчигч тээврийн чиглэлд агаарын тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн нислэгийг сэргээх бодлогыг баримтлан ажилласан бөгөөд орон нутгийн 3 чиглэлд нислэг үйлддэг байсныг 8 болгон нэмэгдүүлж, нислэгийн тийзийн үнийг 2-2.5 дахин хямдруулсан.

Энэхүү бодлогын арга хэмжээний үр дүнд агаарын тээврээр орон нутагт зорчигчдын тоон өсөлт хамгийн өндөр хувиар буюу 25.6%-аар өсч 419.1 мянга болсон байна.

2023 онд төмөр замаар хамгийн их буюу 2.1 сая зорчигч орон нутагт тээвэрлэсэн нь нийт орон нутгийн зорчигч тээврийн 52.7%-ийг эзэлж байна.

2023 ОНД БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ОРЛОГО 7.5 ИХ НАЯД ТӨГРӨГТ ХҮРЧ ӨСЛӨӨ.


Төмөр замын орон нутгийн зорчигчдын тоо өмнөх оноос 10.4%-аар буурахад Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам баригдаж хөдөлгөөн нээсэн, мөн төмөр замын зорчигч тээврийн тариф 50 хүртэл хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.


2023 онд автотээврээр орон нутагт зорчигчдын тоо 1.4 сая болсон нь орон нутагт зорчигчдын 35.8%-ийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оноос 7.2%-аар өсчээ.

2023 онд нийт зорчигч эргэлт 6,492.7 сая хүн/км болж өмнөх оноос 46.1%-аар өсчээ. Үүнээс агаарын тээврийн зорчигч эргэлт хамгийн өндөр хувиар буюу 2.1 дахин өсч, 3,880.8 сая хүн/км болжээ.

Усан замын тээврийн зорчигч эргэлт 33.3%, төмөр замын тээврийн зорчигч эргэлт 13.7%-аар тус тус өссөн бол автотээврийн зорчигч эргэлт 5.3%-аар буурсан байна.

Зураг 19 Зорчигч эргэлт, сая хүн/км






Бүх төрлийн тээврийн орлого 7.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 70.1%-аар өссөн түүхэн өсөлттэй жил байлаа.

Автотээврийн орлого 5.5 их наяд төгрөг болж өмнөх оноос 72.5%-аар, төмөр замын тээврийн орлого 1.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 50.4%-аар, агаарын тээврийн орлого 941.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 83.6%-аар, усан замын тээврийн орлого 1.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.5 дахин өссөн байна.

Зураг 20 Тээврийн орлого, тэрбум төгрөг



2023 онд ачаа болон зорчигч тээврийн хэмжээ нэмэгдсэн нь бүх төрлийн тээврийн орлого өсч түүхэн дээд хэмжээнд хүрэхэд нөлөөлсөн бөгөөд, цар тахлын өмнөх үеэс буюу 2019 оны түвшингээс 3.2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2023 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарим салбарт ачаа болон зорчигч тээврийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглүүлэн тээвэр, логистикийн зардлыг багасгах, үнэ тарифыг тодорхой түвшинд бууруулах бодлого баримтлан ажилласан нь үр дүнгээ өгч, автотээврийн зардал цар тахлын үетэй харьцуулахад 7-8 дахин, агаарын тээврийн тийзийн үнэ 2-2.5 дахин буурсан байна.

Энэхүү бодлогын үр дүнд бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 107.4 сая тонн болж өмнөх оноос 76.6%, үүнээс автотээврээр тээсэн ачаа 2.1 дахин, төмөр замын ачаа тээвэр 30.3%, агаарын тээврийн зорчигчдын тоо 81.7%, үүнээс олон

улсын агаарын тээврийн зорчигчдын тоо 2.1 дахин өссөн.

Мөн 2023 онд цар тахлаас үүдэлтэй зогсоод байсан төмөр зам болон автотээврийн олон улсын зорчигч тээврийн үйл ажиллагааг сэргээсэн нь орлогын өсөлтөд нөлөөлжээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь автотээврийн салбарын орлого өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн байна.

Орлогын өсөлтийг мөнгөн дүнгээр авч үзвэл, автотээврийн орлого 1.5 их наяд төгрөгөөр өссөн нь хамгийн өндөр дүнгээр өссөн үзүүлэлт бол агаарын тээврийн орлого өмнөх оноос 428.9 тэрбум төгрөгөөр, төмөр замын тээврийн орлого 376.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь удаалж байна.

Автотээврийн ачаа тээвэрлэлт 71.3 сая тонн болж 2.1 дахин өссөн нь автотээврийн салбарын орлого өсөхөд голлон нөлөөлжээ. Автотээврийн орлого хамгийн өндөр дүнгээр

өсөхөд экспорт, импортын өсөлт нөлөөлсөн бөгөөд 2023 онд автотээврээр экспортын ачааны 86%, импортын ачааны 45.3%-ийг тээсэн байна.

Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн аялал жуулчлалыг дэмжих бодлого болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас хэрэгжүүлж буй агаарын тээврийн либералчлалын бодлого үр дүнгээ өгч, сүүлийн жилүүдэд цар тахал, валютын ханш, инфляц, үнийн өсөлт зэргээс шалтгаалан зогсонги байдалд ороод байсан агаар, усан замын тээврийн салбарууд хамгийн их өсөлтийг үзүүлж цар тахлын өмнөх түвшинг давж өслөө.

Жишээлбэл Засгийн газрын 2023 оны 201 дүгээр тогтоолын хүрээнд “МИАТ ТӨХК” нь орон нутгийн хуваарьт нислэгийг сэргээж, CRJ-200 маягийн дунд оврын агаарын хөлгөөр 2023 оны 06 дугаар сараас эхлэн Ховд, Улаангом, Мөрөн, Өлгий, Улиастай, Даланзадгад, Чойбалсан, Алтай чиглэлд татаастай нислэгийг үйлдэж агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээг алслагдсан бүс нутгийн иргэдэд үзүүлж, 40-70 хувийн буюу 2-2,5 дахин хямдралтай үнээр ая тухтай зорчих боломж бүрдүүлж, гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлснээр орлогын хэмжээг 800 тэрбум төгрөгөөр давуулан биелүүллээ.

Агаарын тээврээр олон улс, орон нутагт 1.7 сая зорчигч тээвэрлэж өмнөх оноос 81.7%-аар өссөн бол тээврийн орлого 941.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 83.6%-аар өсчээ.


Мөн Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан жуулчдын тоо эрс нэмэгдэж усан замын тээврийн нийт зорчигчдын тоо 64.7 мянга болж өмнөх оноос 71%, үүнээс дотоодын зорчигчийн тоо 62%, гадаадын зорчигчийн тоо

3.6 дахин өсч, тээврийн орлого 1.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.5 дахин өссөн байна.

2023 онд бүх төрлийн тээвэр өндөр өсөлттэй байсан ба төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 54.7%, экспортын ачааны 14%-ийг тээвэрлэжээ.

Төмөр замын орлого 1.1 их наяд хүрснээр УБТЗ-ын дүрмийн сан 167 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2022 онд 60 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан УБТЗ 2023 онд 70 тэрбум төгрөгийн ашигтай ажиллан төмөр замчдын цалинг 15-20%-аар нэмэгдүүлсэн байна.

Зураг 21 Орлогын эзлэх хувь



Автотээврийн салбар нийт ачаа тээврийн 66.4%, улс, хот хоорондын зорчигч тээврийн 36.5% (нийслэлийн зорчигч тээврийг оруулаад 97.3%)-ийг эзэлж байгаа бол орлогын 69%-ийг, төмөр замын салбар ачаа тээврийн 33.6%, зорчигч тээврийн 34.5%, орлогын 17%-ийг, агаарын тээврийн салбар зорчигч тээврийн 27.9%, ачаа тээврийн 0.01%, орлогын 14%-ийг тус тус эзэлж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 83,651 ХҮН АЖИЛЛАЖ БАЙНА.

83 651
Нийт ажилчид

17.3%
Эмэгтэй




82.7%
Эрэгтэй

Зам, тээврийн салбарын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 83.7 мянган албан хаагч ажиллаж байгаа нь өмнөх оноос 15.5 мянгаар буюу 22.7%-аар өсчээ.

Хамгийн их ажиллагсадтай автотээврийн салбарт нийт 47.1 мянган ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас 85.4% нь буюу 40.3 мянга нь мэргэшсэн жолооч байна. Төмөр замын салбарт 17.6 мянган албан хаагч, авто замын салбарт 15.3 мянга албан хаагч, иргэний нисэхийн салбарт 3.5 мянган албан хаагч тус тус ажиллаж байгаа бол усан замын тээврийн салбар 118 албан хаагч ажиллаж байна.

Зураг 22 Зам, тээврийн салбарт ажиллагсад




Салбарын нийт ажиллагсдын 17.3% буюу 14.4 мянга нь эмэгтэй ажилчид байна.


Үүнээс төмөр замын салбарын ажиллагсдын 36.4% буюу 6391, авто замын салбарт 4605 (30%), автотээврийн салбарт 2177 (4.6%), иргэний нисэхийн салбарт 1245 (35.6%), усан замын салбарт 22 (18.6%) эмэгтэй албан хаагчид ажиллаж байна.

Салбарын нийт ажилчдын 56.4% нь автотээврийн, 21.0% нь төмөр замын, 18.3% нь авто замын, 4.2% нь иргэний нисэхийн салбарт ажиллаж байгаа бол усан замын тээврийн салбарт 0.1% нь ажиллаж байна.

Зураг 24 Салбарын дундаж цалин

Зураг 23 Салбарын ажиллагсдын эзлэх хувь






Зам, тээврийн салбарын ажиллагсдын дундаж цалин 2.4 сая төгрөг болж өмнөх оноос 48.1%-аар өссөн байна. Энэ нь Монгол Улсын дундаж цалингаас 20%-аар өндөр байна.

Салбар тус бүрээр ангилж үзвэл автозамын салбар 2.2 сая, автотээвэр 2.2, төмөр замын салбар 2.5 сая төгрөг, иргэний нисэхийн салбар 2.9 сая, усан замын салбар 2.1 сая төгрөгийн дундаж цалинтай байна.

БҮЛЭГ 2. АВТО ЗАМЫН САЛБАР

МОНГОЛ УЛС УЛСЫН ЧАНАРТАЙ 7,535.6 КМ, НИЙТ 10,307 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМТАЙ БАЙНА.

Зураг 25 Улсын чанартай авто зам





Үндэсний авто замын сүлжээний нийт урт 111,916.7 км байдаг бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 14,921.3 км авто зам, орон нутгийн чанартай 96,040 км авто зам, тусгай зориулалтын 955.8 км авто зам байна.

Улсын чанартай 14,921.3 км авто замыг төрлөөр нь ангилвал, хатуу хучилттай авто зам 7,535.6 км, ердийн хөрсөн зам 6,182.7 км, сайжруулсан хөрсөн зам 3,47.3 км, хайрган хучилттай зам 855.7 км байна. Хатуу хучилттай авто замаас 7527.0 км нь асфальт бетон, 8.6 км нь цемент бетон авто зам байна.

Зураг 26 Орон нутгийн чанартай авто зам

Үндэсний авто замын сүлжээний орон нутгийн чанартай 96,040 км авто замыг төрлөөр нь ангилвал, ердийн хөрсөн 93,577.7 км, сайжруулсан хөрсөн 393 км, хайрган хучилттай 255.43 км, хатуу хучилттай 1,813.5 км авто зам байна. Үүнээс хатуу хучилттай замыг 1,778.6 км асфальт бетон, 34.9 км цемент бетон авто зам бүрдүүлж байна.

Зураг 27 Тусгай зориулалтын авто зам




Тусгай зориулалтын хатуу хучилттай 955.8 км авто зам байгаагаас 912.6 км нь асфальт бетон, 43.2 км цемент бетон авто зам байна.


Зураг 28 Улсын чанартай авто замын гүүр

2023 онд улсын хэмжээнд нийт 841.9 урт метр гүүр ашиглалтад орсон. Үүнээс улсын чанартай авто зам дагуу 38 урт метр, орон нутгийн чанартай авто замд 803.9 урт метр гүүрийг ашиглалтад орууллаа.

Улсын чанартай авто зам дагуу нийт 387 гүүр байгаа нь нийлээд 17,266.12 урт метр байна. Үүнээс нийтдээ 15,924.42 урт метр 330 төмөр бетон гүүр, 284 урт метр 1 ган гүүр, 1057.7 урт метр 56 модон гүүр гүүр бүртгэлтэй байна.

Зураг 29 Улсын чанартай авто замын сүлжээ





2023 онд нийт 381.4 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад орууллаа. Үүнээс 221.4 км хатуу хучилттай авто зам шинээр ашиглалтад орсон бол 160 км авто замыг хатуу хучилттай болгож их засвар арчлалт хийж ашиглалтад оруулсан байна.

Ингэснээр олон улс, улсын чанартай 7,535.6 км, орон нутгийн чанартай 1,815.6 км, тусгай зориулалтын 955.8 км, нийт 10,307 км хатуу хучилттай авто замтай болоод байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Азийн авто замын сүлжээний босоо тэнхлэгийн АН-3 чиглэлийн, АН-4 болон хэвтээ тэнхлэгийн АН-32 чиглэл дайран өнгөрдөг.

Орос-Хятадыг хатуу хучилттай авто замаар холбосон Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн 1,002.9 км авто замын сүлжээний Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж, хөдөлгөөнийг бүрэн нээлээ.


Монгол Улсын баруун бүсээр дайран өнгөрдөг баруун босоо тэнхлэгийн АН-4 чиглэлийн 757.1 км авто замыг ашиглалтад бүрэн оруулж, Ази Европыг холбосон авто замын 2 дахь коридорыг нээж, олон улсын тээвэрлэлтийг эхлүүлээ.

Хэвтээ тэнхлэгийн АН-32 чиглэлийн 2,539.3 км авто замын 70 гаруй хувь нь хатуу хучилттай болоод байна.

2023 оны байдлаар 21 аймаг, 104 сум хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдсон бол ОХУ, БНХАУ-тай хиллэдэг 7 боомт хатуу хучилттай авто замтай болоод байна.

Олон улс, улсын чанартай авто замын сүлжээг замын төрлөөр авч үзвэл 50.5% буюу 7,535.6 км хатуу хучилттай, 5.7% буюу 855.7 км хайрган хучилттай, 2.3% буюу 347.3 км нь сайжруулсан хөрсөн зам байгаа бол 41.4% буюу 6,182.7 км нь ердийн хөрсөн зам байна.


Зураг 30 Улсын чанартай авто замын сүлжээний урт км, аймгаар



Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний уртыг аймгуудаар авч үзвэл Дорноговь аймагт 8.3% буюу 1,240.7 км, Өмнөговь аймагт 7.94% буюу 1,184.7 км, Завхан аймагт 7.89% буюу 1,177.1 км, Дорнод аймагт 7.49% буюу 1,117.8 км, Ховд аймагт 6.36% буюу 948.6 км зам ногдож байгаа нь улсын чанартай хамгийн урт авто замын сүлжээтэй аймгууд байна.

Орхон аймагт улсын чанартай 52.2 км авто зам байгаа нь нийт сүлжээний 0.35%-ийг эзлэж байгаа бол Дархан-Уул аймагт 0.64% буюу 95.8 км, Говьсүмбэр аймагт 1.05% буюу 156.2 км, Улаанбаатар хотод 1.68% буюу 251.4 км, Сэлэнгэ аймагт 2.4% буюу 357.6 км байна.

Зураг 31 Улсын чанартай авто замд хатуу хучилттай авто замын эзлэх хувь, урт км



Улсын чанартай авто замд хатуу хучилттай авто замын эзлэх хувийг авч үзвэл, Төв аймаг (671.3 км), Дархан-Уул аймаг (95.8 км), Орхон аймаг (52.2 км) тус бүр 100% хатуу хучилттай байгаа бол Улаанбаатар (249.7 км) 99.3%, Ховд аймаг (769.6 км) 81.1%, Сэлэнгэ аймаг (256.3 км) 70.9%, Архангай аймаг (437 км) 70%, Булган аймаг (437.5 км) 65.6%, Увс аймаг (434.7 км) 65.1%, Хэнтий аймаг (458.2 км) 62.5%, Говьсүмбэр аймаг (97.2 км) 62.2%, Баянхонгор аймаг (279.6 км) 52.4%, Өвөрхангай аймаг (403.1 км) 50.8%, Баян-Өлгий аймаг (233.1 км) 49.6%, Говь-Алтай аймаг (337 км) 49.4%, Завхан аймаг (505.1 км) 42.9%, Өмнөговь аймаг (477.3 км) 37.8%, Дорноговь аймаг (437.5 км) 35.3%, Хөвсгөл аймаг (296.9 км) 33.4%, Дундговь аймаг (246.6 км) 31.4%, Сүхбаатар аймаг (235.7 км) 28.7%, Дорнод аймаг (156.8 км) 14% байна.

БҮЛЭГ 3. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

АВТОТЭЭВРЭЭР УЛС, ХОТ ХООРОНД БОЛОН ХОТ ДОТОР НИЙТ 142.6 САЯ ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛЭЭ.

Зорчигч тээвэр

2023 онд автотээвэрээр нийт 142.6 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 0.3%-аар, зорчигч эргэлт 1813 сая хүн/км болж 5.3%-аар буурсан байна. Үүнд нийслэлийн нийтийн тээвэрээр 140.3 сая зорчигч зорчиж өмнөх оноос 1.0%-аар буурсан нь нөлөөлжээ.

Хот хооронд буюу орон нутагт 1.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 7.2%, олон улсад 850.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 24 дахин өссөн бол хот хоорондын зорчигч эргэлт өмнөх оноос 11.0%-аар өсчээ.




Зураг 32 Автотээврийн зорчигч, сая хүн


Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022
Нийт зорчигч тээвэр	хүн	143,000,004	142,552,993	-0.3%
Олон улсад зорчигчид	хүн	34,716	850,154	2348.9%
Хот хоорондын зорчигч	хүн	1,321,559	1,417,116	7.2%
Хот доторх нийтийн тээвэрээр зорчигч	хүн	141,643,729	140,285,723	-1.0%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	1,914.9	1,813	-5.3%
Хот хооронд зорчигч эргэлт	сая.хүн/км	847.9	941	11.0%
Хот доторх зорчигч эргэлт	сая.хүн/км	1,116.8	872	-21.9%

2023 онд цар тахлын улмаас хаагдаад байсан олон улсын автотээврийн зорчигч тээврийн үйлчилгээг сэргээсэн нь улс хоорондын автотээврийн зорчигчдын тоо өсөхөд нөлөөлжээ.

Зураг 33 Олон улс, орон нутгийн зорчигч тээвэр




Зураг 34 Автотээврийн зорчигч эргэлт



Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчдын тоо буурсан нь автотээврийн зорчигч эргэлт буурахад голлон нөлөөлжээ. Автотээврийн зорчигч эргэлт нийт зорчигч эргэлтийн 27.9%-ийг эзэлж байна.

АВТО ЗАМЫН ХИЛИЙН БООМТООР АВТОТЭЭВРЭЭР 71.3 СЯА ТОНН АЧАА ТЭЭВЭРЛЭЖ 2.1 ДАХИН ӨСЛӨӨ.



Ачаа тээвэр

2023 онд авто замын боомтуудаар нийт 71.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь түүхэн үзүүлэлт боллоо.

2023 оны автотээврийн ачаа өмнөх оноос 2.1 дахин өссөн бөгөөд үүнээс нийт 68.24 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.1 дахин, 3.01 сая тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.8 дахин тус тус өссөн байна.

Автотээврийн ачаа тээвэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022
Нийт тээсэн ачаа	<i>тонн</i>	33,075,601.2	71,254,926.0	115.4%
Ачаа оруулалт - импорт	<i>тонн</i>	1,070,676.5	3,009,969.7	181.1%
БНХАУ-аас	<i>тонн</i>	758,106.8	2,661,057.7	251.0%
ОХУ-аас	<i>тонн</i>	312,569.7	348,912.0	11.6%
Ачаа гаргалт - экспорт	<i>тонн</i>	32,004,924.7	68,244,956.3	113.2%
БНХАУ руу	<i>тонн</i>	31,995,386.6	68,100,329.3	112.8%
ОХУ руу	<i>тонн</i>	9,538.1	144,627.0	1416.3%
Ачаа эргэлт	<i>сая.тонн/км</i>	2,591.9	10,619.1	309.7%

2023 онд тээсэн нийт экспортын ачааны 86%-ийг автотээвэрээр тээжээ.

Зураг 35 Автотээврийн экспортын ачаа




Автотээврийн экспортын ачааны 99.8%-ийг БНХАУ руу тээвэрлэсэн бол, 0.2%-ийг ОХУ руу тээвэрлэжээ.

2023 онд авто замын 13 боомтоор нийт 68.2 сая ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.1 дахин өссөн үзүүлэлт юм. Үүнээс Гашуунсүх боомтоор хамгийн их 53.9% буюу 36.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 88.6%, Шивээхүрэн боомтоор 28.0% буюу 19.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 3.6 дахин, Ханги боомтоор 7.3% буюу 5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 64.1%, Бичигт боомтоор 4.1% буюу 2.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 24.8 дахин, Булган боомтоор 4.0% буюу 2.7 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 22.8%-аар тус тус өсчээ.

Замын-Үүд боомтоор автотээврийн экспортын ачааны 1% буюу 696.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 26.6%-аар өссөн бол ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 54.2 мянган тонн, Цагааннуур боомтоор 90.4 мянган тонн ачаа тус тус тээвэрлэсэн нийлээд өмнөх оноос 17 дахин өссөн байна.

Зураг 36 Экспортын ачаа, эзлэх хувь



2023 онд автотээврээр 66.2 сая тонн нүүрс (2.1 дахин), 627.8 мянган тонн зэсийн баяжмал (25.2%), 524.6 мянган тонн газрын тос (+51.6%), 8.2 мянган тонн жонш (+36.2%), 715.7 мянган тонн бусад ачаа (+12.5 дахин) тээвэрлэсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бол 211.9 мянган тонн төмрийн хүдэр тээвэрлэсэн нь өмнөх оноос 76.8%-аар буурсан байна.

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022
Нүүрс	тонн	30,182,040.0	66,156,637.5	119.2%
Газрын тос	тонн	346,014.0	524,587.0	51.6%
Зэсийн баяжмал	тонн	501,280.0	627,800.0	25.2%
Төмрийн хүдэр	тонн	912,162.0	211,970.0	-76.8%
Жонш	тонн	6,051.0	8,243.0	36.2%
Бусад	тонн	57,377.7	715,718.8	1147.4%

Зураг 37 Автотээврийн импортын ачаа




Автотээврээр 2023 онд импортын ачааны 45.3%-ийг буюу нийт 3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.8 дахин өссөн үзүүлэлт байна.

Импортын тээврийн 88.4%-ийг БНХАУ-тай, 11.6%-ийг ОХУ-тай хиллэдэг боомтуудаар тээвэрлэжээ.

Үүнээс Замын-Үүд боомтоор хамгийн их буюу 1.7 сая тонн (56.7%), Гашуунсухайт боомтоор 28.3% буюу 851.9 мянган тонн, Алтанбулаг боомтоор 6% буюу 181.9 мянган тонн, Цагааннуур боомтоор 4.4% буюу 133.6 мянган тонн, Булган боомтоор 2.4% буюу 73.5 мянган тонн ачаа оруулж ирсэн бол бусад боомтуудаар нийлээд 2.1%-ийг оруулжээ.

Ачаа тээвэр боомтуудаар	2022 он		2023 он	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
Нийт ачаа, тонн	1,070,676.5	32,004,924.7	3,009,969.7	68,244,956.3
Алтанбулаг	183,020.9	8,474.9	181,946.0	54,228.0
Бичигт	10,854.0	111,677.0	-	2,766,118.0
Баянхошуу	23,554.5	346,013.7	12,386.0	528,187.0
Бургастай	1,575.1	866,282.0	20.0	206,339.0
Булган	86,355.2	2,210,694.7	73,492.0	2,714,082.0
Боршоо	29,085.6	1,063.2	33,372.0	-
Гашуунсухайт	-	19,491,012.7	851,950.0	36,750,482.0
Замын-Үүд	635,768.0	550,138.0	1,707,088.0	696,202.0
Цагаан нуур	100,463.2	-	133,594.0	90,399.0
Ханги	-	3,050,832	1,377.0	5,006,071.0
Хавирга	-	-	14,745	320,245.0
Шивээ хүрэн	-	5,368,736.3	-	19,107,076.3
Сүмбэр	-	-	-	5,527.0
БНХАУ	758,106.8	31,995,386.6	2,661,057.7	68,100,329.3
ОХУ	312,569.7	9,538.1	348,912.0	144,627.0
Нийт	33,075,601.2		71,254,926.0	

Зураг 38 Боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, эзлэх хувь



Автозамын боомтуудаар 2023 онд нийт 923,514 ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бол үүнээс 223,224 тээврийн хэрэгсэл хилээр орсон, 700,290 тээврийн хэрэгсэл хилээр гарсан байна.


БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо 804,314 болж өмнөх оноос 2 дахин нэмэгдсэн нь нийт хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн 87.1%-ийг эзэлж байна. 2022 онд энэ үзүүлэлт 75.2% байжээ.

ОХУ-тай хиллэдэг боомтуудаар 119,200 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оноос 8.9%-аар буурсан ба хил нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн 12.9%-ийг эзэлж байна.

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2022 он	2023 он	Өөрчлөлт	2023/2022
Орсон тээврийн хэрэгсэл	94,443	223,224	128,781	136.4%
БНХАУ-аас	73,344	202,331	128,987	175.9%
Бичигт	474	-	-474	-100.0%
Баянхошуу	673	476	-197	-29.3%
Булган	3,654	624	-3,030	-82.9%
Бургастай	3	3	-	-
Гашуунсүхэйт	6,579	4,915	-1,664	-25.3%
Шивээхүрэн	35,130	131,500	96,370	274.3%
Замын-Үүд	25,860	64,209	38,349	148.3%
Ханги	971	168	-803	-82.7%
Хавирга	-	436	436	-
ОХУ-аас	21,099	20,893	-206	-1.0%
Алтанбулаг	11,896	12,686	790	6.6%
Боршоо	1,378	1,461	83	6.0%
Цагааннуур	7,825	6,746	-1,079	-13.8%
Гарсан тээврийн хэрэгсэл	432,490	700,290	267,800	61.9%
БНХАУ-руу	322,741	601,983	279,242	86.5%
Бичигт	1,788	38,159	36,371	2034.2%
Баянхошуу	9,608	16,232	6,624	68.9%
Булган	30,360	34,526	4,166	13.7%
Бургастай	15,494	4,807	-10,687	-69.0%
Гашуунсүхэйт	157,762	266,259	108,497	68.8%
Шивээхүрэн	35,836	166,263	130,427	364.0%
Замын-Үүд	30,364	6,829	-23,535	-77.5%
Ханги	41,529	65,713	24,184	-41.2%
Хавирга	-	3,069	3,069	-
Сүмбэр	-	126	126	-
ОХУ-руу	109,749	98,307	-11,442	-10.4%
Алтанбулаг	100,382	84,151	-16,231	-16.2%
Боршоо	1,345	1,387	42	3.1%
Цагааннуур	8,022	12,769	4,747	59.2%

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД НИЙТ 87,272 МЭРГЭШСЭН ЖОЛООЧ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 39 Мэргэшсэн жолоочийн ангилал



Монгол улсын хэмжээнд 2023 оны эцсийн байдлаар нийт 87,272 мэргэшсэн жолооч бүртгэлтэй байна.

Үүнээс 2023 онд 7,082 иргэн шинээр мэргэшсэн жолооч болжээ.

Нийт мэргэшсэн жолоочийг ангиллаар нь авч үзвэл давхардсан тоогоор В ангиллын 15,098, С ангиллын 30,679, Д ангиллын 25,528, Е ангиллын 63,112 мэргэшсэн жолооч бүртгэлтэй байна.

Мэргэшсэн жолооч	2022 он	2023 он	2023/2022
Нийт мэргэшсэн жолоочийн тоо	80,190	87,272	8.8%
Мэргэшсэн жолоочийн ангилал давхардсан тоогоор нийт	120,662	134,417	11.4%
Үүнээс: В ангилал	14,264	15,098	5.8%
С ангилал	30,187	30,679	1.6%
Д ангилал	22,519	25,528	13.4%
Е ангилал	53,692	63,112	17.5%

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын Мэргэшсэн жолоочийн сургалтын тасаг нь Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 161/229 дугаар тушаалаар баталсан “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ын хүрээнд 2023 онд нийт 13,824 жолоочоос давхардсан тоогоор 47,820 удаагийн шалгалт авснаас 25,261 жолооч шалгалтад тэнцсэн үзүүлэлттэй байна.

2023 онд мэргэшсэн жолоочийн ангиллын хугацаа дууссан жолоочийн сунгалтын шалгалтыг цахимаар 5,465 удаа авч, түүнээс 5,153 нь тэнцжээ.


Мэргэжил дээшлүүлэх			
УХАТ	12,524	9,196	52,797
УХЗТ	110	407	1,855
Жуулчин	169	877	4,891
ААчаа	726	726	5,071
Нийт давхардсан тоогоор	13,529	11,206	64,614

2023 онд нийт 11,206 жолооч мэргэжил дээшлүүлсэн бөгөөд үүнээс улс хоорондын ачаа тээврийн чиглэлээр 9,196 жолооч, улс хоорондын зорчигч тээврийн чиглэлээр 407 жолооч, жуулчин тээврийн чиглэлээр 877 жолооч, аюултай ачаа тээвэрлэлтийн чиглэлээр 726 жолооч тус тус мэргэжил дээшлүүлжээ.

2022 он	2023 он	Бүгд
---------	---------	------

МОНГОЛ УЛСАД 1 192 520 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮРТГЭЛТЭЙ БАЙНА.

Зураг 40 Тээврийн хэрэгслийн ангилал



Тээврийн хэрэгслийг хүрдний байрлалаар авч үзвэл баруун буюу буруу жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл 64.5%, зүүн буюу зөв жолооны хүрдтэй тээврийн хэрэгсэл нь 35.5%-ийг эзэлж байна.

2023 онд баруун хүрдтэй тээврийн хэрэгсэл өмнөх оноос 10.5%-аар, зүүн хүрдтэй тээврийн хэрэгсэл 8.1%-аар нэмэгджээ.

Зураг 41 Жолооны хүрдний байрлал



Хөдөлгүүрийн төрөл


- Бензин	420,128
- Хосолсон	37,7181
- Дизель	305,033
- Хийн	13,711
- Цахилгаан	1,072

Нийт тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн багтаамжаар нь ангилбал:

1500 см ³ хүртэл	451430
1501-2500 см ³	351151
2501-3500 см ³	143744
3501-4500 см ³	12997
4501 см ³	45361

Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,192,520 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь өмнөх оноос 111,308 тээврийн хэрэгслээр буюу 10.3%-аар өссөн байна. Бүх төрлийн тээврийн хэрэгслийн өсөлтийн хувь ойролцоо байгаа нь ангилал тус бүрийн эзлэх хувьд өөрчлөлт оруулаагүй байна.


Хамгийн өндөр дүнгээр өссөн нь суудлын автомашин 72.0 мянгаар буюу 10.1%-аар өссөн бол хамгийн өндөр хувиар өссөн нь чиргүүл 19.3%-аар буюу 11.8 мянгаар өссөн үзүүлэлт байна. Ачааны машин 12.5 мянгаар буюу 6.8%-аар өсчээ.




Тээврийн хэрэгслийг хөдөлгүүрийн төрлөөр ангилбал, 37.6%-ийг бензин, 33.76%-ийг хосолсон, 27.3%-ийг дизель, 1.25%-ийг хийн түлштэй, 0.1%-ийг цахилгаан тээврийн хэрэгсэл эзэлж байна.

Цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн тоо 1,072 болж өмнөх оноос 413 буюу 62.7%-аар өссөн нь хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлт байна.

Зураг 42 Хөдөлгүүрийн багтаамж



Зураг 43 Тээврийн хэрэгслийн импорт – улсаар, тээврийн хэрэгслийн төрлөөр



2023 онд Монгол Улсад нийт 233,866 тээврийн хэрэгсэл импортоор орж ирсэн нь өмнөх оноос 34%-аар өсчээ.

Авто тээврийн хэрэгслийн 2023 оны импортын тоон үзүүлэлтийг экспортлосон улсаар нь авч үзвэл, БНХАУ-аас 142 мянган тээврийн хэрэгсэл буюу 60.7%, Япон улсаас 71.8 мянган тээврийн хэрэгсэл буюу 30.7% нь орж ирсэн бол БНСУ-аас 12.6 мянган тээврийн хэрэгсэл буюу 5.4% нь орж ирсэн нь нийлээд нийт импортлосон тээврийн хэрэгслийн 96.8%-ийг эзэлж байна.


БНХАУ-аас импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос 60.8%-аар, Япон улсаас оруулж ирсэн тээврийн

хэрэгслийн тоо 10.1%-аар тус тус өссөн бол БНСУ болон бусад улс орнуудаас импортлосон тээврийн хэрэгслийн тоо өмнөх оноос буурчээ.

Импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгслийн төрлөөр нь авч үзвэл, 31.5%, буюу 73.4 мянган суудлын авто машин оруулж ирсэн нь өмнөх оноос 12.1%-аар өссөн бол нийтдээ 107 мянган чиргүүл, зүтгүүр зэрэг бусад механизм оруулж ирсэн нь өмнөх оноос бараг 2 дахин өсчээ. Харин ачааны машины импорт өмнөх оноос 4.5%-аар, мотоцикл 5.5%-аар тус тус буурчээ.

Мөн 1,731 нийтийн тээврийн хэрэгсэл, 1,084 тусгай зориулалтын машин тус тус импортлосон байна.

Зураг 44 Автомашины насжилт



10 ба түүнээс дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 974,586 бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 81.7% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна.

0-3 жилийн насжилттай 67,027 тээврийн хэрэгсэл 5.6%, 4-6 жилийн насжилттай 51,570 тээврийн хэрэгсэл 4.3%, 7-9

жилийн насжилттай 99,338 тээврийн хэрэгсэл 8.3%-ийг тус тус эзэлж байна.

2023 онд автотээврийн хэрэгслийн улсын үзлэгт нийт бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 72.2% буюу 861 мянган тээврийн хэрэгсэл хамрагдсан нь өмнөх оны хамрагдалтын хувиас 14.5%-аар илүү байна.


Улаанбаатар хотод 697,870 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 58.5%-ийг, орон нутагт 494,650 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь нийт тээврийн хэрэгслийн 41.5%-ийг эзэлж байна.



	2022 он	2023 он	Улаанбаатар	2023/2022
	Улсын хэмжээнд	Улсын хэмжээнд		
Нийт тээврийн хэрэгсэл	1,081,212	1,192,520	697,870	10.3%
Суудал	716,028	788,038	505,463	10.1%
Ачаа	183,383	195,918	83,482	6.8%
Автобус	21,828	23,356	12,464	7.0%
Тусгай	9,631	10,517	6,923	9.2%
Цистерн	3,664	4,188	2,945	14.3%
Зүтгүүр	42,460	48,949	26,854	15.3%
Механизм	15,045	16,979	11,946	12.9%
Чиргүүл	61,230	73,055	40,078	19.3%
Мотоцикл	27,943	31,520	7,715	12.8%
Жолооны хүрдний байрлал	977,002	1,071,015	638,152	9.6%
Баруун	625,043	690,425	438,307	10.5%
Зүүн	351,959	380,590	199,845	8.1%
Хөдөлгүүрийн төрөл	1,017,642	1,117,125	656,287	9.8%
Бензин	399,748	420,128	231,559	5.1%
Дизель	282,408	305,033	148,619	8.0%
Цахилгаан	659	1,072	977	62.7%
Газ	13,033	13,711	8,373	5.2%
Хосолсон	321,794	377,181	266,759	17.2%
Насжилт	1,081,213	1,192,521	697,871	10.3%
0-3	39,503	67,027	43,779	69.7%
4-6	47,176	51,570	26,678	9.3%
7-9	72,429	99,338	71,930	37.2%
10 ба түүнээс дээш	922,105	974,586	555,484	5.7%
Хөдөлгүүрийн багтаамж	1,017,546	1,115,683	655,018	9.6%
1500 см ³ хүртэл	334,495	351,151	188,948	5.0%
1501-2500 см ³	397,668	451,430	277,287	13.5%
2501-3500 см ³	130,479	143,744	82,481	10.2%
3501-4500 см ³	42,297	45,361	28,453	7.2%
4501 см ³ дээш	112,607	123,997	77,849	10.1%


Орон нутагт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг аймгуудаар задлан авч үзвэл, Өмнөговь аймагт 64,354 буюу 5.4%, Хөвсгөл аймагт 31,564 буюу 2.65%, Орхон аймагт 30,440 буюу 2.55%, Сэлэнгэ аймагт 30,093 буюу 2.52%, Дархан-Уул аймагт 27,871 буюу 2.34%, Өвөрхангай аймагт 27,207 буюу 2.28%, Дорноговь аймагт 26,664 буюу 2.24%, Баян-Өлгий аймагт 25,346 буюу 2.13%, Ховд аймагт 23,799 буюу 2%, Увс аймагт 21,407 буюу 1.8%,

Төв аймагт 21,097 буюу 1.77%, Дорнод аймагт 20,976 буюу 1.76%, Архангай аймагт 20,616 буюу 1.73%, Баянхонгор аймагт 19,969 буюу 1.67%, Хэнтий аймагт 19,821 буюу 1.66%, Завхан аймагт 17,790 буюу 1.49%, Сүхбаатар аймагт 17,370 буюу 1.46%, Булган аймагт 15,429 буюу 1.29%, Говь-Алтай аймаг 14,880 буюу 1.25%, Дундговь аймаг 13,836 буюу 1.16%, Говьсүмбэр 4,121 буюу 0.35% тээврийн хэрэгсэл эзэлж байна.



БҮЛЭГ 4. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

2023 ОНД ТӨМӨР ЗАМААР ОЛОН УЛСАД ЗОРЧИГЧДЫН ТОО 24 ХУВИАР ӨСЛӨӨ.



Зорчигч тээвэр

Төмөр замаар 2023 онд нийт 2,141.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.1%-аар буурсан байна.

Олон улсад 23.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 24.1%-аар өссөн боловч орон нутагт 2,118.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 10.4%-аар буурч, төмөр замын зорчигч тээврийн хэмжээ буурахад нөлөөлжээ.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022 %
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	2,382.8	2,141.8	-10.1%
Олон улс	мян.хүн	19.1	23.7	24.0%
Орон нутаг	мян.хүн	2,363.7	2,118.1	-10.4%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	701.5	797.5	13.7%
Олон улс	сая.хүн/км	7.3	10.9	49.2%
Орон нутаг	сая.хүн/км	694.2	786.6	13.3%

2022 онд бүх төрлийн тээврээр олон улс, орон нутагт зорчигчдын 50.4% нь төмөр замаар зорчиж байсан бол 2023 онд 34.5% болжээ.


2023 онд төмөр замаар хамгийн их буюу 2.1 сая зорчигч орон нутагт тээвэрлэсэн нь нийт орон нутгийн зорчигч тээврийн 52.7%-ийг эзэлж байна. Зорчигчийн тоо өмнөх оноос 10.4%-аар буурахад Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам баригдаж хөдөлгөөн нээсэн, мөн төмөр замын зорчигч тээврийн тариф 50 хүртэл хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Цар тахал, бүс нутгийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан төмөр замын олон улсын зорчигч тээврийн хэмжээ бага байсаар байна. Бүх төрлийн тээврээр олон улсад зорчигчдын тоонд төмөр замын зорчигч тээврийн эзлэх хувь 2023 онд 1.1% байна. 2022 онд зөвхөн Монгол Улс – ОХУ хооронд зорчигч тээвэр хийгдэж байсан бол 2023 оны 8 дугаар сард Монгол улс – БНХАУ хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг сэргээснээр нийтдээ 23.7


мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 24.1%-аар өсчээ.

Төмөр замын тээврийн зорчигч эргэлт 2023 онд 797.5 сая хүн км болж өмнөх оноос 13.7%-аар өсчээ. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 10.9 сая хүн км болж өмнөх оноос 49.2%-аар, орон нутгийн зорчигч эргэлт 786.6 сая хүн км болж өмнөх оноос 13.3%-аар тус тус өссөн байна.

Зураг 46 Төмөр замын зорчигч эргэлт



2023 ОНД ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЧАА 36.1 САЯ ТОНН БОЛЖ 30.3 ХУВИАР ӨСЛӨӨ.



Ачаа тээвэр

Төмөр замаар 2023 онд нийт 36.1 сая тонн ачаа тээвэрлэж түүхэн дээд түвшинд хүрлээ. Ачаа тээврийн хэмжээ өмнөх оноос 30.3%-аар өсчээ.


2023 онд импортын ачаа 3.6 сая тонн болж өмнөх оноос 7.1%-аар буурсан бол дотоодын ачаа 16.3 сая тонн болж өмнөх оноос 35.5%-аар, экспортын ачаа 11.1 сая тонн болж өмнөх оноос 28.8%-аар, дамжин өнгөрөх ачаа 5.1 сая тонн болж өмнөх оноос 60.5%-аар тус тус өссөн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022
Нийт ачаа тээвэр	<i>мян.тн</i>	27,724.9	36,114.2	30.3%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	27,724.9	32,305.4	16.5%
үүнээс "Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	-	1,843.8	-
үүнээс "Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	-	1,965.0	-
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	12,002.0	16,261.3	35.5%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	12,002.0	12,452.6	3.8%
үүнээс "Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	-	1,843.8	-
үүнээс "Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	-	1,965.0	-
Импортын ачаа	<i>мян.тн</i>	3,905.9	3,629.2	-7.1%
БНХАУ-аас	<i>мян.тн</i>	1,693.9	1,130.4	-33.3%
ОХУ-аас	<i>мян.тн</i>	2,212.0	2,498.8	13.0%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	8,642.5	11,129.2	28.8%
БНХАУ руу	<i>мян.тн</i>	8,422.2	10,917.1	29.6%
ОХУ руу	<i>мян.тн</i>	220.3	212.1	-3.7%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	3,174.5	5,094.4	60.5%
БНХАУ-аас ОХУ руу	<i>мян.тн</i>	1,070.8	1,556.3	45.3%
ОХУ-аас БНХАУ руу	<i>мян.тн</i>	2,103.7	3,538.1	68.2%
Ачаа эргэлт	<i>сая.тонн/км</i>	14,910.2	18,869.3	26.6%

Төмөр замын тээврийн нийт ачаа эргэлт 18,869.3 сая тонн км болж өмнөх оноос 26.6%-аар өсчээ.

Үүнээс экспортын ачаа эргэлт 7,952.3 сая тонн км болж өмнөх оноос 26.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа эргэлт 5,654.8 сая тонн км болж 60.5%-аар, орон нутгийн ачаа эргэлт 3,573.6 сая тонн км болж 13.4%-аар тус тус өссөн бол импортын ачаа эргэлт 1,688.7 сая тонн км болж өмнөх оноос 12.9%-аар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 47 Төмөр замын ачаа эргэлт



2023 онд "Улаанбаатар төмөр зам" ХНН 32.3 сая тонн буюу нийт төмөр замын ачаа


тээврийн 89.5%-ийг, “Тавантолгой төмөр зам” ХХК 1,965.0 мянган тонн буюу 5.4%-ийг, Монголын төмөр зам” ТӨХК 1,843.8 мянган тонн буюу 5.1%-ийг тус тус тээвэрлэжээ.

Зураг 48 Төмөр замын тээвэрлэлтэд эзлэх хувь



2023 онд төмөр замаар транзит ачааг 100%, дотоодын ачааны 99.9%, импортын ачааны 54.7%, экспортын ачааны 14%-ийг тус тус тээвэрлэжээ.

Зураг 49 Тээвэрлэлтийн төрлийн эзлэх жин



Төмөр замын ачааг тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл, 16.3 сая тонн буюу 45%-ийг дотоодын ачаа, 11.1 сая тонн буюу 31%-ийг экспортын ачаа, 5.1 сая тонн буюу 14%-ийг дамжин өнгөрөх транзит ачаа, 3.6 сая тонн буюу 10%-ийг импортын ачаа тус тус эзэлж байна.


Төмөр замын экспорт, импорт, дамжин өнгөрөх ачаа тээврийг “Улаанбаатар төмөр зам” ХНН дангаар гүйцэтгэж байна.

Төмөр замын улс хоорондын ачаа тээврийг ОХУ-тай Алтанбулаг, Эрээнцав, БНХАУ-тай Замын-Үүд гэсэн төмөр замын 3 боомтоор хийж байна.

2023 онд анх удаа Замын-Үүд-Эрээний галт тэрэг солилцоо хоногт өргөн царигаар 16, нарийн царигаар 8 галт тэрэг болж нэмэгдсэн нь төмөр замаар тээсэн улс хоорондын ачаа тээврийн хэмжээ өсөхөд нөлөөлжээ.

Төмөр замаар улс хооронд буюу экспорт, импортын нийт 14.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 17.6%-аар өсчээ.

Зураг 50 Төмөр замын улс хоорондын ачаа тээвэр, эзлэх хувь




БНХАУ-тай хийсэн тээвэрлэлт 81.6% буюу 12.0 сая тонн болсон нь өмнөх оноос 19.1%-аар, ОХУ-тай хийсэн тээвэрлэлт 18.4% буюу 2.7 сая тонн болсон нь 11.5%-аар өсчээ. Үүнээс БНХАУ-тай хийсэн ачаа тээврийн 90.6% нь экспортын ачаа байсан бол ОХУ-тай хийсэн ачаа тээврийн 92.2 нь импортын ачаа тээвэр байжээ.

Улс хоорондын ачаа тээвэрт тээвэрлэлтийн төрлийн эзлэх хувиар авч үзвэл БНХАУ руу тээвэрлэсэн экспортын ачаа хамгийн өндөр дүнтэй буюу 10.9 сая тонн байгаа нь 74%-ийг эзэлж байна. Харин ОХУ-аас оруулж ирсэн импортын ачааны тээвэрлэлт 16.9%-ийг эзэлж байна.

Экспортын тээврийн 11.1 сая тонн ачааны 98% буюу 10.9 сая тонн ачааг БНХАУ руу гаргасан бол, 2% буюу 0.2 сая тонн ачааг ОХУ руу гаргажээ. Өмнөх онтой харьцуулбал БНХАУ руу гаргасан экспортын тээврийн хэмжээ 29.6%-аар өссөн бол ОХУ руу гаргасан экспортын тээврийн хэмжээ 3.7%-аар буурсан байна.


Зураг 51 Төмөр замын экспортын тээврийн хэмжээ, эзлэх хувь



Төмөр замын тээврийн импортын 3.6 сая тонн ачааны 69% буюу 2.5 сая тонныг ОХУ-аас, 31% буюу 1.1 сая тонныг БНХАУ-аас оруулж ирсэн байна. Өмнөх онтой харьцуулбал ОХУ-аас орж ирсэн ачаа 13%-аар өссөн бол, БНХАУ-аас орж ирсэн ачаа 33.3%-аар буурчээ.

Төмөр замаар тээвэрлэсэн импортын ачааны хэмжээ буурахад автотээврийн өртөг зардал буурсан, БНХАУ-ын Замын-Үүд, Гашуунсухайт боомтоор орж ирсэн автотээврийн импортын ачаа тээвэрлэлт эрс нэмэгдсэн нь нөлөөлжээ.


Зураг 52 Төмөр замын импортын тээврийн хэмжээ, эзлэх хувь



Төмөр замаар дамжин өнгөрсөн 5.1 сая тонн ачааны 69.5% буюу 3.5 сая тонн ачааг ОХУ-аас БНХАУ руу дамжуулан тээвэрлэсэн нь өмнөх оноос 68.2%-аар өссөн бол БНХАУ-аас ОХУ руу тээвэрлэсэн дамжин өнгөрөх ачаа 30.5%-ийг эзэлж байгаа бөгөөд 1.6 сая тонн болж өмнөх оноос 45.3%-аар өссөн байна.


Транзит тээврийн хэмжээ өсөхөд ОХУ, БНХАУ хоорондын худалдаа эрчимжсэн нь нөлөөлжээ.

Зураг 53 Төмөр замаар дамжин өнгөрсөн ачаа тээврийн хэмжээ, эзлэх хувь



2023 онд Монголын төрийн өмчит төмөр замын тээврийн компаниуд ачаа тээвэрлэлтээ эхлүүлж, дотоодын ачааг тээвэрлэлээ.

Зураг 54 Дотоодын тээвэрлэлтийн эзлэх хувь



Дотоодод тээвэрлэсэн 16.3 сая тонн ачааны 12.5 сая тонн ачаа буюу 77%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.8 сая тонн ачаа буюу 11%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 1.96 сая тонн ачаа буюу 12%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК тус тус эзэлж байна.


Төмөр замын байгууллагууд эрчим хүчний нүүрс, шахмал түлшний түүхий эдийн тээврийг бүрэн хариуцан нийгмийн хариуцлагын хүрээнд тээвэрлэсэн нь дотоодын ачааны өсөлтөд нөлөөлжээ.

2023 онд төмөр замаар дотоодод болон гадаадад тээвэрлэсэн ачааг нэр төрлөөр нь ангилбал, уул уурхайн бүтээгдэхүүн 24.3 сая тонн буюу 88.5%, барилгын материал 1.9 сая тонн буюу 6.9%, хүнсний бүтээгдэхүүн 278 мянган тонн буюу 1.0%, хар төмөр 257 мянган тонн буюу 0.9%, ХАА-н бүтээгдэхүүн 79.4 мянган тонн буюу 0.3%, мод модон материал 59.6 мянган тонн 0.2%, тоног төхөөрөмж 31.2 мянган тонн буюу 0.1%, түргэн муудах бүтээгдэхүүн 1.9 мянган тонн 0.01%, бусад 552.5 мянган тонн 2.0% ачааг тус тус тээвэрлэсэн байна.

Зураг 55 Төмөр замаар тээсэн ачааны төрөл



Зураг 56 Төмөр замаар тээсэн ачааны өөрчлөлт




2023 онд төмөр замаар дотоодод болон гадаадад тээвэрлэсэн бүтээгдэхүүнийг өмнөх онтой харьцуулахад, хүнсний бүтээгдэхүүн 52.5%, уул уурхайн бүтээгдэхүүн 43.8%, тоног төхөөрөмж 43.1%, хар төмөр 29.1%, бусад ачаа 12.3%-аар тус тус өсчээ. Харин түргэн муудах бүтээгдэхүүний тээвэр 54.8%, ХАА-н бүтээгдэхүүн 50.8%, барилгын материал 29.2%, мод модон материал 5.7%-аар тус тус өмнөх оноос буусан байна.

Төмөр замаар тээвэрлэсэн уул уурхайн бүтээгдэхүүнийг дотор нь нэр төрлөөр нь авч үзвэл, 16.5 сая тонн нүүрс болон мидлинг тээвэрлэсэн нь өмнөх оноос 46.6%, 5.4 сая тонн төмрийн хүдэр тээвэрлэсэн нь 38.1%, 1 сая тонн жонш, жоншны баяжмал тээвэрлэсэн нь 164%,

493.1 мянган тонн нефть тээвэрлэсэн нь 44.1%-аар өссөн бол 675.2 мянган зэс болон молибдений баяжмал тээвэрлэсэн нь 5.1%-аар буурчээ.

Зураг 57 Уул уурхайн бүтээгдэхүүний нэр төрөл




ТӨМӨР ЗАМЫН БООМТООР ХОНОГТ 16 ГАЛТ ТЭРЭГ СОЛИЛЦОЖ, СОЛИЛЦСОН

ВАГОНЫ ТООГ 26.3 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭЭ.

Монгол Улс төмөр замын 3 боомтоор хөрш улс орнуудтайгаа харилцан тээвэр хийж байна. 2023 онд хилийн боомтоор хоногт 16 хүртэл галт тэрэг солилцсон нь түүхэн үзүүлэлт боллоо.

2023 онд нийтдээ 1,129,270 вагон солилцсон нь өмнөх оноос 26.3%-аар, үүнээс ачаатай 716,436 вагон солилцсон нь өмнөх оноос 30.8%-аар өсчээ.

Зураг 58 Хүлээн авсан вагон




Хилээр нийт 536,433 вагон хүлээн авсан нь өмнөх оноос 24.3%, үүнээс ачаатай 317,615 вагон хүлээн авсан нь 26.4%-аар өсчээ.

Хилээр хүлээн авсан нийт вагоны 71% буюу 380,682 нь Эрлээн өртөөнөөс хүлээн авсан

вагон байгаа бөгөөд өмнөх оноос 22%-аар өссөн байна.

Замын хэмжээнд нийт хүлээн авсан вагоны 59.2% (2022 онд 58.2%) нь ачаатай байсан бол Наушки өртөөнөөс хүлээн авсан вагоны 96.3%, Соловьевск өртөөнөөс 59.2%, Эрлээн өртөөнөөс 44.3% нь ачаатай байжээ.

Зураг 59 Хүлээлгэн өгсөн вагон



Төмөр замын хилээр нийт 592,837 вагон хүлээлгэн өгсөн нь өмнөх оноос 28.2%-аар, үүнээс ачаатай 398,821 вагон хүлээлгэн өгсөн нь 34.5%-аар өсчээ.

Хүлээлгэн өгсөн вагонд ачаатай вагоны эзлэх хувь 67.3% болж өмнөх оноос 3.2 пунктээр нэмэгджээ. Үүнээс Наушки өртөөнд 68.2%, Эрлээн өртөөнд 67%, Соловьевск өртөөнд 47.5% нь ачаатай бүртгэгдсэн байна.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны гүйцэтгэл	Өсөлт, бууралтын %
Нийт солилцсон вагон	вагон	894,101	1,129,270	26.3%
Хилээр хүлээн авсан вагон	ачаатай вагон	547,908	716,436	30.8%
	вагон	431,635	536,433	24.3%
Наушки өртөөнөөс	ачаатай вагон	251,317	317,615	26.4%
	вагон	117,087	153,329	31.0%
Эрлээн өртөөнөөс	ачаатай вагон	112,692	147,593	31.0%
	вагон	312,159	380,682	22.0%
Соловьевск өртөөнөөс	ачаатай вагон	137,688	168,741	22.6%
	вагон	2,389	2,422	1.4%
Хилээр хүлээлгэн өгсөн вагон	ачаатай вагон	937	1,281	36.7%
	вагон	462,466	592,837	28.2%
Наушки өртөөнд	ачаатай вагон	296,591	398,821	34.5%
	вагон	111,778	158,592	41.9%
Эрлээн өртөөнд	ачаатай вагон	71,828	108,176	50.6%
	вагон	348,357	431,820	24.0%
Соловьевск өртөөнд	ачаатай вагон	223,362	289,494	29.6%
	вагон	2,331	2,425	4.0%
	ачаатай вагон	1,401	1,151	-17.8%


2023 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД 12,354 ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН БҮРТГЭГДЭЖ, ЗҮТГҮҮРИЙН ТООГ 5.6 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЛЭЭ.

Төмөр замын салбарт 2023 оны 12 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар хөдлөх бүрэлдэхүүний нийт тоо 12,235 байгаагаас хагас

вагон 6,874, тавцант вагон 2,439, зорчигчийн вагон 321, зүтгүүр 190, машин механизм 83, бусад 2,328 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байна.

Нийт хөдлөх бүрэлдэхүүний тоо	12,354
Хагас вагон	6,874
Тавцант вагон	2,439
Бусад	2,328
Зорчигчийн вагон	321
Зүтгүүрийн тоо	190
Машин механизм	83
<hr/>	
Эзэмшигч байгууллагаар	
УБТЗ-д	3,726
ТӨХК-д	498
Хувийн хэвшил	8,011


Зураг 60 Хөдлөх бүрэлдэхүүний төрөл



Хөдлөх бүрэлдэхүүнийг төрлөөр нь авч үзвэл, 56.2% нь хагас вагон байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол дараа нь тавцант вагон 19.9%, зорчигчийн вагон 2.6%, зүтгүүр 1.6%, машин механизм 0.7%-ийг тус тус эзэлж байна.

2023 онд зүтгүүрийн тоо өмнөх оноос 10-аар нэмэгдэж, 190 болсон бол хагас вагон, тавцант вагоны тоо мөн өссөн үзүүлэлттэй байна. Харин зорчигчийн вагоны тоо 3.3%-аар буурчээ.

Зураг 61 Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч



Хөдлөх бүрэлдэхүүнийг эзэмшдэг байгууллагаар нь авч үзвэл хувийн хэвшил 8,011 хөдлөх бүрэлдэхүүн буюу 66%-ийг, “Улаанбаатар төмөр зам” ХНН 3,406 хөдлөх бүрэлдэхүүн буюу 30%-ийг, төрийн өмчит компаниуд 498 хөдлөх бүрэлдэхүүн буюу 4%-ийг тус тус эзэмшиж байна.

Хувийн хэвшлийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүний тоо өмнөх оноос 64.1%-аар өссөн бол “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүний 3.7%-аар буурчээ.

2024 онд Зам, тээврийн хөгжлийн яамнаас төмөр замын ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор зүтгүүр болон ачааны вагоны тоог тодорхой хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөөд байна.


2023 ОНД МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНИЙ ДЭЛГЭМЭЛ УРТ 286.9 КМ-ЭЭР НЭМЭГДЭЖ, НИЙТ УРТ 3,349.6 КМ БОЛЛОО.

Сүүлийн 3 жилийн хугацаанд төмөр замын сүлжээний гол замын уртыг 928 км-ээр, салбар замын уртыг 192.1 км-ээр, нийт уртыг 1,120.1 км-ээр нэмэгдүүлжээ.

Үүнээс 2021 онд 16.3 км, 2022 онд 816.9 км, 2023 онд 286.9 км-ээр тус тус нэмэгдүүлжээ.

Ингэснээр Монгол Улсын төмөр замын сүлжээний нийт урт 3,349.6 км болсон бөгөөд үүнээс гол төмөр замын урт 2,413.0 км, салбар төмөр замын урт 936.6 км байна.

Зураг 62 Төмөр замын сүлжээний урт



Төмөр замын сүлжээг өргөжүүлэх хүрээнд 2021 онд Тавантолгойн ачилтын тойргийн 16.3 км төмөр замыг барьж ашиглалтад оруулсан бол 2022 онд Замын-Үүд - Шаргын-Овоо чиглэлийн 14.3 км хос төмөр замын туршилтийн тээврийг эхлүүлж, ашиглалтад авчээ.

Мөн 2022 онд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416 км (дэлгэмэл урт 462.5 км) төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233.6 км (дэлгэмэл урт 312.9 км) төмөр зам, Тавантолгой – Гашуунсухайт болон Тавантолгой-Зүүнбаян холболтын 21.1 км (дэлгэмэл урт 27.3 км) төмөр замыг барьж, туршилтын тээврийг тус


2023 оны байдлаар төмөр замын сүлжээнд 8 аймаг, 46 сум, 3 боомт холбогдсон байна. Монгол Улсын төмөр замын сүлжээний Алтанбулаг-Замын-Үүд чиглэлийн төмөр зам нь Орос, Монгол, Хятад улсын эдийн засгийн төв коридор бөгөөд төмөр замаар дамжин өнгөрөх болон экспорт, импортын тээврийн гол дэд бүтэц байна.

тус эхлүүлж, 2023 онд байнгын ашиглалтад хүлээн авсан.

Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км (дэлгэмэл урт 286.9 км) төмөр замын барилгын ажлыг дуусгаж, 2023 оны эхнээс зүгшрүүлэх туршилтын тээвэрлэлтийг эхлүүлсэн бөгөөд 2024 онд байнгын ашиглалтад хүлээн авахаар бэлтгэл хангаж байна.


Монгол Улс төмөр замын суурь бүтэц эзэмшигч төр, хувийн хэвшлийн нийт 6 байгууллагатай болсноор үндэсний төмөр замын сүлжээтэй болоод байна.

Зураг 63 Суурь бүтэц эзэмшигч



Монгол Улсын төмөр замын сүлжээний суурь бүтцийн 62%-ийг буюу 2,063.2 км замыг “Улаанбаатар төмөр зам” ХНН, 15%-ийг буюу 495.9 км төмөр замыг “Монголын төмөр зам” ТӨХК, 11%-ийг буюу 356.5 км төмөр замыг “Тавантолгой төмөр зам” ХХК, 8%-ийг буюу 286.9 км төмөр замыг “Монголиан транс лайн” ХХК, 3%-ийг буюу 120 км төмөр замыг “Болдтөмөр Ерөө гол” ХХК тус тус эзэмшиж байгаа бол 1% буюу 27.1 км төмөр зам нь Газрын тос боловсруулах үйлдвэрт харьяалагдаж байна.

Зураг 64 Монгол Улсын үндэсний төмөр замын сүлжээ



БҮЛЭГ 5. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР


АГААРЫН ТЭЭВРЭЭР **1.7 САЯ** ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЖ ӨМНӨХ ОНООС **81.7 ХУВИАР** ӨСЛӨӨ.



Агаарын тээврээр зорчигчдын 76%-ийг олон улсын зорчигчид эзэлж байгаа бол 24%-ийг орон нутгийн зорчигчид эзэлж байна.

Олон улсад зорчигчдын тоо 2023 онд 1.3 сая болж өмнөх оноос 112%-аар өссөн бөгөөд нийт бүх төрлийн тээврээр олон улсад зорчигчдын 60.0%-ийг эзэлж байна. Мөн орон нутагт зорчигчдын тоо 2023 онд 419.1 мянга болж өмнөх оноос 25.6%-аар өсчээ.

Зураг 65 Олон улс, орон нутагт зорчигчдын эзлэх хувь




Зорчигч тээвэр

2023 онд агаарын тээврээр зорчигчдын тоо 1.7 саяд хүрч өмнөх оноос 81.7%-аар өссөн байна.

Агаарын тээврийн зорчигч тээвэр бусад салбарын зорчигч тээврээс хамгийн өндөр хувиар өсөхөд олон улсын болон дотоодын нислэгийн тийзийн үнийг 2-2.5 дахин хямдруулсан, орон нутгийн нислэгийн чиглэлийг нэмэгдүүлсэн, “Агаарын харилцааны тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Америкийн Нэгдсэн Улс, Катар, Грек, Лаос улстай тус тус байгуулснаар Монгол Улс дэлхийн 43 улсын 122 цэг рүү нислэг үйлдэх боломжтой болсон нь нөлөөлжээ.

Зураг 66 Зорчигч тээврийн үзүүлэлтүүд



Зорчигч эргэлт 2023 онд нийт 3,880.8 сая хүн/км болж өмнөх оноос 2.1 дахин өсчээ. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 3,628.3 сая хүн/км болж өмнөх оноос 2.1 дахин, орон нутгийн зорчигч эргэлт 252.5 сая хүн/км болж өмнөх оноос 33.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2022 он	2023 он	2023/2022
Нийт зорчигч тээвэр	хүн	952,765	1,731,291	81.7%
олон улсад	хүн	618,960	1,312,167	112.0%
орон нутагт	хүн	333,805	419,124	25.6%
Зорчигч эргэлт	сая.хүн/км	1,828.4	3,880.8	112.3%
олон улсад	сая.хүн/км	1,639.4	3,628.3	121.3%
орон нутагт	сая.хүн/км	189.0	252.5	33.6%


Зураг 67 Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



Зураг 68 Олон улсын зорчигч, чиглэлээр



Зураг 69 Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгчээр



2023 оны байдлаар 43 улсын 122 чиглэлд нислэг үйлдэх томилгоог агаарын тээвэрлэгчдэд олгосон байна.

2023 онд Сөүл чиглэлд хамгийн их 43.6% нь буюу 572.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 94.8%, Станбул чиглэлд 10.7% буюу 140.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 28.9%, Бээжин чиглэлд 9.6% буюу 125.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 45 дахин, Франкфурт чиглэлд 7.5% буюу 71.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 44.3%, Хонгконг чиглэлд 5.3% буюу 69.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь 25 дахин, Бусан чиглэлд 4.8% буюу 63.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь 3.3 дахин бусад чиглэлд 13.1% буюу 172.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 82.5%-аар тус тус өсчээ.

Агаарын тээвэрлэгчээр авч үзвэл, “МИАТ” ТӨХК хамгийн их 50.6% нь буюу 663.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 132.7%, “Korean Air” 11.8% буюу 154.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь 70.8%, “Asiana Airlines 6.7% буюу 87.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь 98.4%, “Turkish Airlines” 6.6% буюу 86.7 мянган зорчигч тээвэрлэсэн нь 20.5%, “Airchina” 4.9% буюу 64.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь 13 дахин, “Хүннү Эйр” ХХК 4.3% буюу 56.6 мянган зорчигч тээвэрлэсэн нь 75.8%, “Аэро Монголиа” ХХК 4.0% буюу 52.2 мянган зорчигч тээвэрлэсэн нь 43.1% бусад тээвэрлэгч 11.2% буюу 147.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь 173.3%-аар тус тус өсчээ.

Олон улсад зорчигчдын 59.6%-ийг дотоодын 5 компани тээвэрлэжээ.

Агаарын тээврээр орон нутагт 2023 онд нийт 419.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 25.6%-аар өссөн.


Зураг 70 Орон нутгийн зорчигч, чиглэлээр



Үүнээс Оюутолгой чиглэлд хамгийн их 85.2% нь буюу 356.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 22.5%, Өлгий чиглэлд 3.1% буюу 13.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 31.2%, Ховд чиглэлд 2.7% буюу 11.3 мянган

зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.2%, Мөрөн чиглэлд 2.6% буюу 11.0 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 3.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 71 Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгчээр



Орон нутгийн зорчигч тээврийн хэмжээг агаарын тээвэрлэгчээр авч үзвэл, “МИАТ” ТӨХК хамгийн их 53.3% нь буюу 223.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 43.6%, “Аэро Монголиа” 26.3% буюу 110.4 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 0.6%, “Хүннү Эйр” ХХК 20.3% буюу 85.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 40.3%-аар тус тус өссөн байна.

Орон нутгийн чиглэл		2022 он	2023 он	2023/2022
Нийт орон нутгийн зорчигч		333,805	419,124	25.6%
1	Оюутолгой	291,470	356,912	22.5%
2	Өлгий	9,970	13,076	31.2%
3	Ховд	10,941	11,287	3.2%
4	Мөрөн	3,165	11,014	248.0%
5	Даланзадгад	2,001	8,663	332.9%
6	Улиастай	5,080	5,969	17.5%
7	Улаангом	1,450	4,246	192.8%
8	Алтай	1,049	3,033	189.1%
9	Чойбалсан	94	2,670	2740.4%
10	Баянхонгор	131	130	-0.8%
11	Бусад	8,454	2,124	-74.9%
Агаарын тээвэрлэгч тус бүрээр				
1	MIAT	155,635	223,515	43.6%
2	Aero Mongolia	109,686	110,389	0.6%
3	Hunnu air	60,655	85,124	40.3%
4	Mongolian airways cargo	8,270	0	-100.0%
5	GEOSAN	13	96	638.5%

АГААРЫН ТЭЭВРЭЭР 8.6 МЯНГАН ТОНН АЧАА, ШУУДАН ТЭЭВЭРЛЭЛЭЭ.



Ачаа тээвэр


